

*Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк*

**СТАНДАРТ НӨХЦӨЛ, ШААРДЛАГУУД**

**2021 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр**

**Энэхүү баримт бичигт Банкны үйл ажиллагаандаа баримтлах нийтлэг зарчим, практикийг тусгасан ба түүнд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж болно.**



## АГУУЛГА

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – СТАНДАРТ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

1.01 дэх Хэсэг. Стандарт Нөхцөл, Шаардлагыг хэрэглэх нь .....1

1.02 дахь Хэсэг. Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээтэй зөрчилдөх нь .....1

### ХОЁРДУГААР ЗҮЙЛ – ИШЛЭЛ, ГАРЧИГ; НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....1

2.01 дахь Хэсэг. Стандарт Нөхцөл, Шаардлагыг Тайлбарлах нь .....1

2.02 дахь Хэсэг. Нэр томьёоны тодорхойлолт.....2

### ГУРАВДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛ ТАТАН АВАЛТ; НӨХӨН ТӨЛӨХ ҮҮРЭГ; ХҮҮ, БУСАД ШИМТГЭЛҮҮД; ЗЭЭЛ НӨХӨН ТӨЛӨЛТ .....13

3.01 дахь Хэсэг. Зээл Татан Авалт.....13

3.02 дахь Хэсэг. Нөхцөлт ба Нөхцөлт Бус Нөхөн Төлөх Үүрэг .....14

3.03 дахь Хэсэг. Зээлийн Хөрөнгийг Дахин Хуваарилах .....14

3.04 дэх Хэсэг. Хүү .....15

3.05 дахь Хэсэг. Үүргийн Шимтгэл ба Зээл Олгосны Шимтгэл .....17

3.06 дахь Хэсэг. Зээлдэгчийн Төлбөрүүд .....18

3.07 дахь Хэсэг. Зээлийг Хугацаанаас Өмнө Төлөх .....18

3.08 дахь Хэсэг. Зээлийг Цуцлах.....19

3.09 дэх Хэсэг. Хугацаа Хэтэрсний Хүү.....19

3.10 дахь Хэсэг. [Зээлийн] Нөхцөлийн Өөрчлөлтийн Зардал .....20

3.11 дэх Хэсэг. Төлбөрийн Валют, Хэлбэр, Хэмжээ .....22

3.12 дахь Хэсэг. Хураамж, Зардлууд .....22

3.13 дахь Хэсэг. Зах Зээл Тогтворгүйжих .....22

### ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ .....23

4.01 дахь Хэсэг. Хамтран Ажиллах, Мэдээлэл Солилцох .....23

4.02 дахь Хэсэг. Төслийг Хэрэгжүүлэх Үүрэг .....24

4.03 дахь Хэсэг. Худалдан Авалт .....25

4.04 дэх Хэсэг. Төслийн Тайлан, Баримт Бичгүүд .....26

### ТАВДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ .....27


5.01 дахь Хэсэг. Гуравдагч Талд Давуу Байдал Үл Үүсгэх.....27

5.02 дахь Хэсэгт. Мэдээ Тайлан .....28


### ЗУРГААДУГААР ЗҮЙЛ – ТАТВАР; ТӨЛБӨРТ ХЯЗГААРЛАЛТ ҮЛ ТОГТООХ .....29

6.01 дахь Хэсэг. Татвар .....29

6.02 дахь Хэсэг. Төлбөрийг Үл Хязгаарлах .....30



|                                                                                                       |           |
|-------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>ДОЛООДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ;<br/>ТҮРГЭСГЭЖ ТӨЛӨХ.....</b>                      | <b>30</b> |
| 7.01 дэх Хэсэг. Түдгэлзүүлэх.....                                                                     | 30        |
| 7.02 дахь Хэсэг. Банкны Санаачилгаар Зээлийг Цуцлах .....                                             | 33        |
| 7.03 дахь Хэсэг. Зээлийг Түдгэлзүүлсэн, Цуцалсан нь Нөхцөлт Бус Нөхөн Төлөх<br>Үүргийг Үл Хөндөх..... | 34        |
| 7.04 дэх Хэсэг. Зээлдэгч, Батлан Даагчийн Үүрэг.....                                                  | 34        |
| 7.05 дахь Хэсэг. Батлан Даалтын Үүрэг Дуусгавар Болох .....                                           | 34        |
| 7.06 дахь Хэсэг. Зээлийг Түргэсгэж Төлүүлэх.....                                                      | 34        |
| <b>НАЙМДУГААР ЗҮЙЛ – ШҮҮХИЙН ЖУРМААР АЛБАДАН БИЕЛҮҮЛЭХ;<br/>МАРГААН ШИЙДВЭРЛЭХ .....</b>              | <b>35</b> |
| 8.01 дэх Хэсэг. Шүүхийн Журмаар Албадан Биелүүлэх .....                                               | 35        |
| 8.02 дахь Хэсэг. Батлан Даагчийн Үүрэг.....                                                           | 35        |
| 8.03 дахь Хэсэг. Эрхээ Эс Эдлэх .....                                                                 | 36        |
| 8.04 дэх Хэсэг. Маргаан Шийдвэрлэх.....                                                               | 36        |
| <b>ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ – ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ДУУСГАВАР БОЛОХ.....</b>                                     | <b>38</b> |
| 9.01 дэх Хэсэг. Гэрээ Хүчин Төгөлдөр Болох Өдөр.....                                                  | 38        |
| 9.02 дахь Хэсэг. Гэрээ Хүчин Төгөлдөр Болох Урьдач Нөхцлүүд .....                                     | 38        |
| 9.03 дахь Хэсэг. Хууль Зүйн Дүгнэлт .....                                                             | 39        |
| 9.04 дэх Хэсэг. Хүчин Төгөлдөр Болоогүй Үндэслэлээр Гэрээг Дуусгавар Болгох .....                     | 39        |
| 9.05 дахь Хэсэг. Гэрээг Биелүүлснээр Дуусгавар Болгох.....                                            | 39        |
| <b>АРАВДУГААР ЗҮЙЛ – МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ; ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ;<br/>НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ .....</b>           | <b>40</b> |
| 10.01 дэх Хэсэг. Мэдэгдэл Хүргүүлэх .....                                                             | 40        |
| 10.02 дахь Хэсэг. Бүрэн Эрх .....                                                                     | 40        |
| 10.03 дахь Хэсэг. Нэмэлт Өөрчлөлт.....                                                                | 40        |
| 10.04 дэх Хэсэг. Англи Хэл .....                                                                      | 41        |
| 10.05 дахь Хэсэг. Гэрээг Үйлдэх Хувь .....                                                            | 41        |
| 10.06 дахь Хэсэг. Мэдээллийн Ил Тод Байдал .....                                                      | 41        |



## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ – СТАНДАРТ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ХЭРЭГЛЭХ НЬ

### 1.01 дэх Хэсэг. Стандарт Нөхцөл, Шаардлагыг хэрэглэх нь

(a) Банкнаас Банкны гишүүн аливаа оронтой байгуулсан, зээл, батлан даалт, эсвэл бусад санхүүгийн гэрээ хэлцэл, эсвэл Банкны гишүүн аливаа орны зүгээс батлан даасан зээл, батлан даалт, эсвэл бусад санхүүгийн гэрээ хэлцэл нь энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагыг дагаж мөрдөхийг зөвшөөрч болно. Ийнхүү дагаж мөрдөхөөр тухайн гэрээнд заасан тохиолдолд Стандарт Нөхцөл, Шаардлагыг уг гэрээнд бүхэлд нь тусгасан мэт нэгэн адил мөрдөнө. Тухайн гэрээний талууд тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд Стандарт Нөхцөл, Шаардлагыг цуцалсан, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан нь уг гэрээнд хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.

(b) Дараах тохиолдолд дор дурдсан нэр томьёо бүхий зүйл заалтыг мөрдөхгүй (үл хэрэглэнэ):

- (i) Банк, Банкны гишүүн хоёрын хооронд Зээлийн хэлэлцээрийг байгуулах тохиолдолд Стандарт Нөхцөл, Шаардлагад заасан “Батлан даагч”, “Батлан даалтын Гэрээ”, “Батлан Даагчийн Эрх бүхий Төлөөлөгч” гэсэн нэр томьёо бүхий заалтыг үл хэрэглэнэ;
- (ii) Төслийн Гэрээ байхгүй тохиолдолд Стандарт Нөхцөл, Шаардлагад заасан “Төслийн Гэрээ” гэсэн нэр томьёо бүхий заалтыг үл хэрэглэнэ;
- (iii) Төслийг бүхэлд нь Зээлдэгч хэрэгжүүлэх тохиолдолд Стандарт Нөхцөл, Шаардлагад заасан “Төсөл Хэрэгжүүлэгч” гэсэн нэр томьёо бүхий заалтыг үл хэрэглэнэ.

### 1.02 дахь Хэсэг.Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээтэй зөрчилдөх нь


Дээрх 1.01(а)-д заасан гэрээний аливаа зүйл нь энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагын аливаа зүйлтэй зөрчилдөх тохиолдолд тухайн гэрээний зүйлийг дагаж мөрдөнө.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ – ИШЛЭЛ, ГАРЧИГ; НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.01 дахь Хэсэг.Стандарт Нөхцөл, Шаардлагыг Тайлбарлах нь

(a) Энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад заасан Зүйл, Хэсэг нь энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагын Зүйл, Заалтыг илэрхийлнэ гэж ойлгоно.

(b) Энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад, эсвэл Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх тухайн гэрээнд заасан, агуулгаар өөрөөр тайлбарлах шаардлагагүй бол ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн нь ганц тоог давхар илэрхийлэх ба “этгээд” гэж дурдсан нь компани, нөхөрлөл, аливаа бусад хуулийн этгээдийг ойлгох ба



“этгээд” гэдэгт тэдгээрийн эрх залгамжлагч, зөвшөөрөгдсөн эрх шилжүүлэн хүлээн авагчийг багтаан илэрхийлнэ.

(с) Энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад, эсвэл Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх тухайн гэрээнд Зүйл, Хэсгийн нэр болон Агуулгыг зөвхөн ишлэхэд хялбар байлгах зорилгоор оруулсан бөгөөд энэ нь Стандарт Нөхцөл, Шаардлага, эсвэл тухайн гэрээг тайлбарлахад нөлөөлөхгүй болно.

(d) Энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад эсвэл 1.01 дэх Хэсэгт заасны дагуу энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлага хамаарах аливаа гэрээнд хувь хэмжээ харуулсан мэдээллийн үйлчилгээний индекс, хуудас эсвэл дэлгэцийг иш татсан нь:

(i) тухайн хувь хэмжээ харуулсан мэдээллийн үйлчилгээний индекс, хуудас, дэлгэцийг орлуулах индекс, хуудас, дэлгэцийг; болон

(ii) тухайн мэдээллийн үйлчилгээний оронд тухайн хувь хэмжээг тухай бүр харуулдаг бусад мэдээллийн үйлчилгээний зохих индекс, хуудас, дэлгэцийг багтаах ба

тухайн индекс, хуудас, дэлгэц, үйлчилгээг ашиглах боломжгүй болсон тохиолдолд Банкнаас Зээлдэгч болон Батлан даагчид заасан, хувь хэмжээг харуулсан бусад индекс, хуудас, үйлчилгээг багтаана.

## 2.02 дахь Хэсэг. Нэр томъёоны тодорхойлолт


Өөрөөр заагаагүй бол Энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад, эсвэл Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх тухайн гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

"Хамаарал бүхий этгээд" аливаа этгээдийн хувьд түүнийг шууд болон шууд бусаар удирдаж байгаа, түүний Хяналтад байгаа, эсвэл нэг Хяналт дор байгаа бусад этгээдийг ойлгоно.


"ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулсан Гэрээ" Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг Үүсгэн Байгуулах тухай 1990 оны 5 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Гэрээг ойлгоно.

"Хөрөнгө" аливаа төрлийн хөрөнгө, орлого, шаардах эрхийг ойлгоно.

"Боломжит Үлдэгдэл" [Зээлийн хэлэлцээрийн хэдийд ч] Зээлийн хөрөнгийн цуцлаагүй, эсвэл Зээлдэгчийн авч хэрэглээгүй байгаа, эсвэл нөхцөлт Нөхөн Төлөх Үүрэг, нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэгт хамрагдаагүй Зээлийн хэсгийг ойлгоно.




|                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| "Банк"                            | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкныг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| "Банкны Төлөөлөгч"                | Банкны хөдөлмөрийн гэрээт ажилтан, эсхүл Банктай гэрээ байгуулсан зөвлөх, агент, төлөөлөгчийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| "Зээлдэгч"                        | Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээл авсан талыг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| "Зээлдэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч" | ийнхүү төлөөлөхөөр Зээлийн хэлэлцээрт заасан этгээдийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| "Ажлын Өдөр"                      | <p>(i) Зээлийн валют нь Ам.Доллар бол</p> <p>(a) Английн Лондон хотод арилжааны банкууд ердийн бизнес (гадаад валютын гүйлгээ болон гадаад валютын хадгаламж)-ийн гүйлгээ хийхээр нээлттэй байдаг бөгөөд АНУ-ын Нью Йорк хотод арилжааны банкууд ба гадаад валютын зах зээлийн оролцогчид Ам.Доллароор илэрхийлсэн төлбөр тооцоо хийдэг өдрийг, мөн</p> <p>(b) (x) Зээлийн Хүү тооцох Мөчлөгийн эхний буюу сүүлийн өдрийг тодорхойлохтой холбоотой, эсвэл тухайн Хүү тооцох Мөчлөгийн уртыг тодорхойлохтой холбоотой бусад тохиолдолд, (y) Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн эхний эсвэл сүүлийн өдрийг тодорхойлохтой холбоотой, эсвэл тухайн Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн уртыг тодорхойлохтой холбоотой бусад тохиолдолд, эсвэл (z) Зээлийн аль нэг хэсгийг Хүү Төлөх Өдөр эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн сүүлийн өдрөөс өөр өдөр төлөх ёстой болсон тохиолдолд хүү тооцох холбогдох мөчлөгийн сүүлийн өдөр болон уртыг тодорхойлохтой холбоотойгоор Үнэт цаасны Зах зээл, Санхүүгийн Зах зээлийн Холбооноос (эсвэл түүний эрх залгамжлагч байгууллага) АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах зорилгоор гишүүдийнхээ тогтмол орлоготой хэлтсүүдийг бүтэн өдрийн турш хаахыг зөвлөдөг өдрөөс бусад өдрийг, эсвэл</p> <p>(ii) Зээлийн валют нь Евро бол Английн Лондон хотод арилжааны банкууд ердийн бизнес (гадаад валютын гүйлгээ болон гадаад валютын хадгаламж)-ийн гүйлгээ хийхээр нээлттэй байдаг бөгөөд TARGET Системийн Ажлын Өдрийг (үүнд, бямба, ням гарагийг үл оруулна)</p> |
| "Зардлын Ангилал"                 | Зээлийн хэлэлцээрт заасны дагуу Зээлийн санхүүжүүлэх зардлын ангиллыг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |





|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|---------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| "Шимтгэлүүд"                                | Зээлтэй холбоотой аливаа шимтгэл, хураамж, төлбөр, нэмэгдэл, [Зээлийн] Нөхцөлийн Өөрчлөлттэй холбоотой Зардал, хугацаа хэтрүүлсний хүүг ойлгоно.                                                                                                                                                                                                            |
| "Хамтран Зээлдүүлэгч"                       | 7.01(а)(х) Хэсэгт заасан Хамтын Зээлийг олгож буй (Банкнаас бусад) зээлдүүлэгчийг ойлгоно; Зээлийн хэлэлцээрт нэгээс илүү тооны зээлдүүлэгчийг заасан бол "Хамтран Зээлдүүлэгч" нь эдгээр зээлдүүлэгч тус бүрийг илэрхийлнэ.                                                                                                                                |
| "Хамтын Зээл"                               | 7.01(а)(х) Хэсэгт заасан бөгөөд Зээлийн хэлэлцээрийн дагуу Хамтран Зээлдүүлэгчээс олгосон (эсвэл олгох) санхүүжилтийг ойлгоно; Зээлийн хэлэлцээрт нэгээс илүү санхүүжилтийг заасан бол "Хамтын Зээл" нь эдгээр санхүүжилт тус бүрийг илэрхийлнэ.                                                                                                            |
| "Хамтын Зээлийн хэлэлцээр"                  | 7.01(а)(х) Хэсэгт заасан, Хамтын Зээлийг олгох тухай гэрээг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                        |
| "Хамтын Зээлийн Эцсийн Өдөр"                | 7.01(а)(х) Хэсэгт заасан бөгөөд Зээлийн хэлэлцээрт зааснаар Хамтын Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрийг ойлгоно. Зээлийн хэлэлцээрт эцсийн өдрийг нэгээс илүү заасан бол "Хамтын Зээлийн Эцсийн Өдөр" нь эдгээр огноо тус бүрийг илэрхийлнэ.                                                                                                       |
| "Үүргийн Шимтгэл"                           | 3.05(а) Хэсэгт заасан шимтгэлийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| "Хяналт"                                    | аливаа этгээд, эсвэл хуулийн этгээдийн хувьд тухайн этгээд, эсвэл хуулийн этгээдийн менежмент, бодлогыг чиглүүлэх, эсвэл чиглэхэд нөлөө үзүүлэх эрх мэдлийг шууд буюу шууд бусаар, саналын эрх, гэрээ, бусад байдлаар эдлэхийг ойлгоно (үүнд, "хяналт дор байх", "хянадаг", "нэгдсэн хяналт дор байх" гэсэн харилцан хамааралтай агуулгыг мөн хамааруулна). |
| "Зээлийн Тохируулгын Зөрүү"                 | Зээлийн хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| "Валют"                                     | тухай орны Засгийн Газрын болон хувийн хэвшлийн өрийг төлөхөд ашигладаг, хууль ёсны төлбөрийн хэрэгслийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                           |
| "Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тодорхойлох Өдөр" | Ам.Долларын тохиолдолд тухайн Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн хувьд уг Мөчлөгийн эхний өдрөөс 2 (хоёр) Лондонгийн Банкны Өдрийн өмнөх өдөр (эсвэл Банк өөрөө сонгосон бол Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн                                                                                                                               |



эхний өдөр)-ийг; Фунт Стерлингийн тохиолдолд тухайн Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн эхний өдрийг; Еврогийн тохиолдолд тухайн Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн хувьд уг Мөчлөгийн эхний өдрөөс 2 (хоёр) Ажлын Өдрийн өмнөх өдрийг тус тус ойлгоно.

"Нийтэд Мэдээлэх"

Банкны Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журамд заасан утгаар ойлгоно.

"Ам.Доллар"

Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг ойлгоно.

"Зээл Татан Авалт"

Банк Зээлдэгчид, эсвэл Зээлдэгчийн даалгаварт заасны дагуу нэг, эсвэл хэд хэдэн төлбөрийг хийх замаар Зээлдэгч Боломжит Үлдэгдлийн хэсгээс ашиглаж зарцуулахыг ойлгоно.

"ЕСБХБ-ны Зээлийн Журам"

Банкнаас зээл олгох журам, түүнд тухай бүр орсон нэмэлт өөрчлөлтийг ойлгоно.

"ЕСБХБ-ны Худалдан Авалтын Журам"

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны зүгээс санхүүжүүлсэн төсөлд баримтлах Худалдан Авалтын Журмыг, түүнд тухай бүр орсон нэмэлт, өөрчлөлтийг ойлгоно.

"Хүчин Төгөлдөр болох Өдөр"

9.01 дэх Хэсэгт заасны дагуу Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрийг ойлгоно.

"Албадан Хэрэгжүүлэх"


Банкны Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журамд заасан утгаар ойлгоно.

"Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журам"

гэж Зээлийн хэлэлцээрт заасан өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй, тухай бүр нэмэлт, өөрчлөлт ордог, Банкны Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журмыг, эсхүл түүний оронд батлагдсан аливаа шинэ бодлого, журмыг тус тус ойлгоно.


"Евро"

Европын Хамтын Нийгэмлэгийг Үүсгэн Байгуулах тухай Хэлэлцээрийн дагуу нэгдмэл мөнгөн тэмдэгтийг баталсан, улмаар Европын Холбооны Хэлэлцээрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан, Европын Холбооны гишүүн орнуудын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг ойлгоно.





|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| "Гадаад Өр"                               | ЕСБХБ-ны Гишүүний Валютаас өөр валютаар төлөх буюу төлж болзошгүй өрийг ойлгоно.                                                                                                                                                                                                                     |
| "Тогтмол Хүүгийн Хувь"                    | 3.04(d) дэх Хэсэгт заасны дагуу төлөх Зээлийн хүүгийн хувийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                |
| "Зээл Олгосны Шимтгэл"                    | 3.05(b) Хэсэгт заасан шимтгэлийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                            |
| "Батлан Даалтын Гэрээ"                    | Зээлийн эргэн төлөлтийг батлан даах тухай нэг талаас Банк, нөгөө талаас ЕСБХБ-ны Гишүүний хоорондын гэрээ, түүнд тухай бүр орсон нэмэлт өөрчлөлтийг ойлгоно. "Батлан Даалтын Гэрээ" гэсэнд түүний хавсралтууд, дагалдах бусад гэрээнүүд, мөн эдгээр Стандарт Нөхцөл, Шаардлагыг мөн тус тус ойлгоно. |
| "Батлан Даагч"                            | Батлан Даалтын Гэрээний тал болж оролцож буй ЕСБХБ-ны Гишүүнийг ойлгоно.                                                                                                                                                                                                                             |
| "Батлан Даагчийн Эрх бүхий Төлөөлөгч"     | ийнхүү төлөөлөхөөр Батлан Даалтын Гэрээнд заасан этгээдийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                  |
| "Өр Үүсгэх"                               | өр бий болгох, түүнийг батлан даахыг ойлгоно, мөн тухайн өр, эсвэл түүний батлан даалтыг шинэчлэх, хугацааг нь сунгах, нэмэлт өөрчлөлт оруулахыг мөн ойлгоно.                                                                                                                                        |
| "Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Өдөр"    | 3.04(c)(ii) Хэсэгт заасны дагуу Зээлдэгчийн сонгосон Хүү Төлөх Өдрийг ойлгоно.                                                                                                                                                                                                                       |
| "Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Мөчлөг"  | 3.04(c)(ii) Хэсэгт заасны дагуу Зээлдэгчийн сонгож, Хүү Төлөх Өдрөөс эхлэн өөр нэг Хүү Төлөх Өдөр хүртэл, 1-ээс доошгүй жил үргэлжлэх хугацааг ойлгоно.                                                                                                                                              |
| "Тогтмол Хүүгийн Хувийг Тодорхойлох Өдөр" | тухайн Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Мөчлөгийн эхний өдрөөс хамгийн багадаа хоёр Ажлын Өдрийн өмнөх Ажлын Өдрийг ойлгоно.                                                                                                                                                                          |
| "Хүү Төлөх Өдөр"                          | Зээлийн хүүг төлөхөөр Зээлийн хэлэлцээрт заасан өдрийг ойлгоно. Хэрэв Хүү Төлөх Өдөр нь Ажлын Өдөр бус өдөр таарсан тохиолдолд тухайн Хүү Төлөх Өдрийг тухайн хуанлийн сар дахь дараагийн Ажлын Өдөр, эсхүл тухайн                                                                                   |



хуанлийн сард дараагийн Ажлын Өдөр байхгүй тохиолдолд шууд өмнөх Ажлын Өдөр рүү шилжүүлнэ.

"Хүүг Тооцох Мөчлөг"

аливаа Зээл Татан Авалтын хувьд, тухайн Зээл Татан Авалтын өдрөөс эхлэн дараагийн Хүү Төлөх Өдрөөр дуусгавар болох бөгөөд дараагийн мөчлөг бүр Хүү Төлөх Өдрөөс эхэлж дараагийн Хүү Төлөх Өдрөөр дуусгавар болох мөчлөгийг ойлгоно. Хэрэв Зээл Татан Авалтыг дараагийн Хүү Төлөх Өдрөөс 15 (арван тав)-аас цөөн Ажлын Өдрийн өмнө хийх тохиолдолд тухайн Зээл Татан Авалтын эхний Хүүг Тооцох Мөчлөгийг тухайн Зээл Татан Авалтын өдрөөс эхлэн тоолж, дараагийн Хүү Төлөх Өдрийн дараагийн Хүү Төлөх Өдөр дуусна гэж үзнэ.

"Хүүгийн Хувь"

Зээлийн хэлэлцээрт заасан Тогтмол Хүүгийн Хувь, эсвэл Хувьсагч Хүүгийн Хувийг, эсвэл эдгээр хоёрыг (Зээлийн хэлэлцээрт заасан бол) хамтад нь ойлгоно. Хэрэв Тогтмол Хүүгийн Хувийг Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 3.04(с) Хэсгийн дагуу тогтоосон бол Тогтмол Хүүгийн Хувийг 3.04(с)(iii) Хэсэгт заасны дагуу Зээлдэгч, Батлан Даагчаас Банкинд ирүүлсэн мэдэгдэлд зааснаар ойлгоно.

"IPAM"

2019 оны 4-р сарын Төслийн Хариуцлагын Бодлогын хүрээнд тусгагдсан Банкны Төслийн Хараат бус Хариуцлагын Механизмын тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчилсэн хувилбарыг ойлгоно.

"Зээл Олгох Сүүлчийн Өдөр"

Зээлийн хэлэлцээрт зээл олгох сүүлчийн өдөр гэж заасан өдрийг ойлгоно.

"Барьцааны Эрхүүд"

аливаа ипотека, барьцаа, онцгой эрх, давуу эрх болон эдгээртэй адил үр дагавар бүхий бусад аливаа эрхийн хязгаарлалтыг ойлгоно.

"Зээл"


Зээлийн хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.

"Зээлийн хэлэлцээр"


эдгээр Стандарт Нөхцөл, Шаардлагыг мөрдөх зээлийн хэлэлцээр, түүнд тухай бүр орсон нэмэлт өөрчлөлтийг ойлгоно. "Зээлийн хэлэлцээр" гэсэнд түүний хавсралтууд, дагалдах бусад гэрээнүүд, мөн эдгээр Стандарт Нөхцөл, Шаардлагыг мөн тус тус ойлгоно.

"Зээлийн Валют"

Зээлийг илэрхийлсэн, Зээлийн хэлэлцээрт заасан нэг буюу хэд хэдэн Валютыг ойлгоно.



|                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|----------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| "Зээл Эргэн Төлөх Өдөр"                      | Зээлийн үндсэн дүнг эргүүлэн төлөхөөр Зээлийн хэлэлцээрт заасан өдрийг ойлгоно. Хэрэв Зээл Эргэн Төлөх Өдөр нь Ажлын Өдөр бус өдөр таарсан тохиолдолд тухайн Зээл Эргэн Төлөх Өдрийг тухайн хуанлийн сар дахь дараагийн Ажлын Өдөр, эсхүл тухайн хуанлийн сард дараагийн Ажлын Өдөр байхгүй тохиолдолд шууд өмнөх Ажлын Өдөр рүү шилжүүлнэ. |
| "Маржин"                                     | жилийн нэг хувийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| "Зах Зээл Тогтворгүйжих<br>Үйл Явдал"        | (a) Зээлийн Валют нь Евро бол Хавсралт 1 ( <i>Еврогоор Илэрхийлсэн Зээл</i> )-ийн II Хэсэгт заасан утгаар; эсвэл<br><br>(b) Зээлийн Валют нь Ам.Доллар бол Хавсралт 2 ( <i>Ам.Доллороор Илэрхийлсэн Зээл</i> )-ийн II Хэсэгт заасан утгаар ойлгоно.                                                                                         |
| "ЕСБХБ-ны Гишүүн"                            | Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл 1.01(a) Хэсэгт заасан бусад гэрээний тал, Банкны гишүүнийг ойлгоно.                                                                                                                                                                                                                          |
| "Зээл Цуцлах Доод<br>Хэмжээ"                 | Зээлийн хэлэлцээрт заасан холбогдох дүнг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                           |
| "Зээл Татан Авалтын<br>Доод Хэмжээ"          | Зээлийн хэлэлцээрт заасан холбогдох дүнг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                           |
| "Зээл Хугацаанаас Өмнө Төлөх<br>Доод Хэмжээ" | Зээлийн хэлэлцээрт заасан холбогдох дүнг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                           |
| "Хориглосон Үйл<br>Ажиллагаа"                | Зээлийн хэлэлцээрийг байгуулах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Банкны Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журамд заасан утгыг ойлгоно.                                                                                                                                                                                                  |
| "Төсөл"                                      | Зээлийн хэлэлцээр, эсвэл Батлан Даалтын Гэрээнд заасны дагуу Зээлээр санхүүжүүлэх төсөл, түүнд талуудын гэрээгээр тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийг ойлгоно.                                                                                                                                                                            |
| "Төслийн Гэрээ"                              | Зээлийн хэлэлцээр, эсвэл Батлан Даалтын Гэрээнд заасан аливаа төслийн гэрээ, түүнд талуудын гэрээгээр тухай бүр оруулсан нэмэлт өөрчлөлтийг ойлгоно. "Төслийн Гэрээ" гэсэнд түүний хавсралтууд, дагалдах бусад гэрээнүүд, мөн эдгээр Стандарт Нөхцөл, Шаардлагыг мөн тус тус ойлгоно.                                                       |
| "Төсөл Хэрэгжүүлэгч"                         | Зээлийн хэлэлцээрт заасан этгээдийг ойлгоно.                                                                                                                                                                                                                                                                                                |
| "Төсөл Хэрэгжүүлэгчийн                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                             |



Эрх Бүхий Төлөөлөгч"

тухайн Төсөл Хэрэгжүүлэгчийн хувьд, түүнийг ийнхүү төлөөлөхөөр тухайн Төслийн Гэрээнд заасан этгээдийг ойлгоно.

"Төрийн Өмч"

ЕСБХБ-ны Гишүүн, эсвэл түүний өмчийн эрх, удирдлага дор оршдог, эсвэл түүний өмнөөс буюу түүний эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг аливаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хөрөнгө, эсвэл ЕСБХБ-ны Гишүүний төв банк, валютын тогтворжуулалтын нөөц сангийн чиг үүрэг, эсвэл үүнтэй төстэй чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн алт, гадаад валютын Хөрөнгийг тус тус ойлгоно.

"Референц Хуудас"

Евро-гоор илэрхийлсэн Зээлийн хувьд, Ройтерс-ын мэдээнд EURIBOR01 хуудас (эсхүл тухайн Еврогоор илэрхийлсэн хадгаламжид санал болгож буй Евро бүсийн банк хоорондын хувь хэмжээг харуулах, Ройтерс-ын мэдээний EURIBOR01 хуудсыг орлох өөр бусад хуудас) гэж тодорхойлсон тухайн Еврогоор илэрхийлсэн хадгаламжид томоохон банкуудын санал болгож буй Евро бүсийн банк хоорондын хувь хэмжээг харуулсан дэлгэцийн хуудсыг тус тус ойлгоно.

## "Нөхөн Төлөх Үүрэг"

3.02 дахь Хэсэгт заасан үүргийг ойлгоно. "Нөхөн Төлөх Үүрэг" нь 3.02 дахь Хэсэгт зааснаар "нөхцөлт Нөхөн Төлөх Үүрэг", эсвэл "нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэг" гэсэн хэлбэртэй байж болно.

"Холбогдох Зах Зээлийн  
Хүүгийн Хувь"

Зээлийн Валют нь евро бол Хавсралт 1 (*Еврогоор Илэрхийлсэн Зээл*)-д заасан хүүгийн хувийг, Зээлийн Валют нь Ам.Доллар бол Хавсралт 2 (*Ам.Доллароор Илэрхийлсэн Зээл*)-д заасан хүүгийн хувийг тус тус ойлгоно.


"Үүсгэн Байгуулах  
Баримт Бичиг"

Зээлдэгч (ЕСБХБ-ны Гишүүн биш тохиолдолд), эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн хувьд, үүсгэн байгуулах дүрэм, шийдвэр, тогтоол, үүнтэй адил бусад баримт бичгийг (Зээлийн хэлэлцээр, эсвэл тухайн Төслийн Гэрээнд илүү тодорхой зааж болно) тус тус ойлгоно.

## "Охин Компани"

аливаа этгээдийн хувьд, тухайн этгээд өөрийн хөрөнгийнх нь 50 (тавь) болон түүнээс дээш хувийг шууд буюу шууд бус байдлаар эзэмшдэг буюу тухайн этгээд бусад байдлаар үр нөлөөтэйгөөр удирддаг аливаа бусад хуулийн этгээдийг ойлгоно.

## "TARGET Системийн



Ажлын Өдөр"

Транс-Европын Автоматжуулсан Бодит Цагийн Нэг Бүрчилсэн Төлбөр Тооцооны Экспресс Шилжүүлгийн Систем (*Trans-European Automated Real-Time Gross Settlement Express Transfer System* буюу *TARGET System*) Еврогийн төлбөр тооцоог гүйцэтгэхээр нээлттэй байх өдрийг ойлгоно.

"Татвар"

Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээг байгуулах үед ЕСБХБ-ны Гишүүний нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр мөрдөж байсан болон түүнээс хойш ногдуулсан аливаа татвар, хураамж, төлбөрийг ойлгох боловч эдгээрээр хязгаарлахгүй.

"Транч"

Зээлийн хэлэлцээрт заасан, Зээлийн зарим хэсгийг ойлгоно.


"[Зээлийн] Нөхцөлийн  
Өөрчлөлттэй холбоотой  
Зардал"

(I) Доорх II заалтад өөрөөр зааснаас бусад тохиолдолд, Анхдагч Орлогын Дүн нь Орлогч Орлогын Дүнгээс давсан дүнг ойлгоно. Үүнд:

(a) "Анхдагч Орлогын Дүн" гэж [Зээл, түүний хэсгийг] хугацаанаас нь өмнө төлөх, түргэсгэж төлөх, эсвэл бүрмөсөн цуцлах үйл явдал бий болоогүй байсан сан, улмаар Зээлийн тухайн дүнд Тогтмол Хүүгийн Хувийн (3.04(d) Хэсэгт заасны дагуу) үйлчлэх хугацаанд Тогтмол Хувиар (дор тодорхойлсон), бусад хугацаанд зохих Хөвөгч Хувиар тус тус тооцсон хүүгийн орлого хуримтлагдах байсан сан бол Тооцооны Хугацаан дахь (дор тодорхойлсон) Тогтмол Хүүгийн Хувь бүхий Зээлийн тухайн дүнд ногдож, улмаар Банкинд төлөх байсан Зээлийн зохих үндсэн дүн ба хүүгийн өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг ойлгоно.

(b) "Орлогч Орлогын Дүн" гэж дараах дүнгүүдийн нийлбэрийг ойлгоно. Үүнд:

(1) [Зээл, түүний хэсгийг] хугацаанаас нь өмнө төлөх, түргэсгэж төлөх, эсвэл бүрмөсөн цуцлах үйл явдлын улмаас тухайн Зээлийн хүүг Тогтмол Хүүгийн Хувийн (3.04(d) Хэсэгт заасны дагуу) үйлчлэх хугацаанд Тогтмол Хувиар, бусад хугацаанд зохих Хөвөгч Хувиар тооцох тохиолдолд Тооцооны Хугацаан дахь Тогтмол Хүүгийн Хувь бүхий тухайн Зээлд ногдож, улмаар Банкинд төлөх аливаа үлдэгдэл үндсэн дүн ба хүүгийн өнөөгийн үнэ цэнэ, болон



(2) доорх нөхцөл байдлаас хамааран:

(А) 3.07 дахь Хэсгийн дагуу хугацаанаас нь өмнө төлөх Зээлийн хувьд ийнхүү урьдчилж төлж буй, Тогтмол Хүүгийн Хувь бүхий Зээлийн өнөөгийн үнэ цэнийг ийнхүү төлөх өдрөөс Тооцооны Өдөр (дор тодорхойлсон) хүртэлх хугацаанд Дискоунт Хувиар (дор тодорхойлсон) хорогдуулсны дараах дүн; ба/эсвэл

(В) аливаа бусад хугацаанаас нь өмнө төлөх тохиолдлын хувьд Тогтмол Хүүгийн Хувь бүхий, урьдчилан төлсөн Зээлийн дүн; ба/эсвэл

(С) түргэсгэж төлөх Зээлийн хувьд түргэсгэж буй, Тогтмол Хүүгийн Хувь бүхий Зээлийн өнөөгийн үнэ цэнийг ийнхүү түргэсгэж төлөх өдрөөс Тооцооны Өдөр хүртэлх хугацаанд Дискоунт Хувиар хорогдуулсны дараах дүн; ба/эсвэл


(D) цуцлах Зээлийн хувьд цуцлагдаж буй, Тогтмол Хүүгийн Хувь бүхий Зээлийн өнөөгийн үнэ цэнийг Зээл Олгох Сүүлчийн Өдрөөс Тооцооны Өдөр хүртэлх хугацаанд Дискоунт Хувиар хорогдуулсны дараах дүн.

(с) "Тогтмол хувь" гэж Тогтмол Хүүгийн Хувиас Маржиныг хассан ялгаврыг ойлгоно.

(d) Дээрх (I)(a), (I)(b)(1) Хэсгүүдийн хувьд, эдгээрт заасан үндсэн дүн, хүүг төлөхөд түүний өнөөгийн үнэ цэнийг тооцоход тухайн төлбөр бүрийг төлөх ёстой өдрөөс Тооцооны Өдөр хүртэлх хугацаанд Дискоунт Хувиар хорогдуулж тодорхойлно.

(е) "Тооцооны Өдөр" гэж:

(1) 3.07 дахь Хэсгийн дагуу хугацаанаас нь өмнө төлөх Зээлийн хувьд, ийнхүү урьдчилан төлөх ёстой өдрөөс өмнөх 2 (хоёр) дахь Ажлын Өдөр (эсвэл Банкны өөрийн сонгож, хугацаанаас нь өмнө төлөх өдөр)-ийг ойлгоно;





(2) аливаа бусад хугацаанаас нь өмнө төлөх тохиолдлын хувьд ийнхүү урьдчилан төлсөн тухайн өдөр, эсвэл үүнээс хойших, Банкны өөрийн сонгосон өөр өдрийг ойлгоно;

(3) түргэсгэж төлөх, эсвэл цуцлах Зээлийн хувьд, ийнхүү түргэсгэж төлсөн өдөр, эсвэл цуцалсан өдрөөс өмнөх 2 (хоёр) дахь Ажлын Өдөр (эсвэл Банкны өөрийн сонгосон өдөр)-ийг ойлгоно;

(f) "Тооцооны Хугацаа" гэж:

(1) 3.07 дахь Хэсгийн дагуу хугацаанаас нь өмнө төлөх Зээлийн хувьд, ийнхүү урьдчилан төлөх ёстой өдрөөс хамгийн сүүлчийн Зээл Эргэн Төлөх Өдөр хүртэлх хугацааг ойлгоно;


(2) аливаа бусад хугацаанаас нь өмнө төлөх тохиолдлын хувьд ийнхүү урьдчилан төлсөн тухайн өдрөөс (эсвэл үүнээс хойших, Банкны өөрийн сонгосон өөр өдрөөс) хамгийн сүүлчийн Зээл Эргэн Төлөх Өдөр хүртэлх хугацааг ойлгоно;

(3) түргэсгэж төлөх, эсвэл цуцлах Зээлийн хувьд, ийнхүү түргэсгэж төлсөн өдөр, эсвэл цуцалсан өдрөөс хамгийн сүүлчийн Зээл Эргэн Төлөх Өдөр хүртэлх хугацааг ойлгоно.

(g) "Дискоунт Хувь" гэж Тооцооны Өдрийн байдлаар хүүгийн своп, опционы зах зээл дээр, Зээлийн Валютын свопын мурийн үзүүлэлтэд үндэслэн Банкнаас тогтоосон, [Зээлийг] эргэн төлөх тухайн хугацаанд тохирох хямдралын коэффициентийг ойлгоно.

(h) "Хөвөгч Хувь" гэж Тооцооны Өдрийн байдлаар хүүгийн своп, опционы зах зээлд Банкнаас тогтоосон [Зээлийг] эргэн төлөх тухайн хугацаанд тохирох Ам.Доллар эсвэл Еврогийн форвард ханшийг тус тус ойлгоно.

(II) Дээрх (I) заалтад заасныг үл харгалзан, Тогтмол Хүүгийн Хувь бүхий Зээлийн аливаа хэсгийн хувьд Зээл Олгох Сүүлчийн Өдрийг (Зээлийн хэлэлцээрт заасны дагуу Банкны зөвшөөрснөөр) хойшлуулсан тохиолдолд "Нөхцөлийн



Өөрчлөлттэй холбоотой Зардал" гэж Банкнаас Зээлдэгч, Батлан Даагчид бичгээр тухай бүр мэдэгдсэн мөнгөн дүнг ойлгоно.

"Хувьсагч Хүүгийн Хувь" 3.04(d) дэх Хэсэгт заасны дагуу төлөх Зээлийн хүүгийн хувийг ойлгоно.

## **ГУРАВДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛ ТАТАН АВАЛТ; НӨХӨН ТӨЛӨХ ҮҮРЭГ; ХҮҮ, БУСАД ШИМТГЭЛҮҮД: ЗЭЭЛ НӨХӨН ТӨЛӨЛТ**

### **3.01 дахь Хэсэг. Зээл Татан Авалт**

Зээлдэгчид Зээлийн хэлэлцээрт заасны дагуу Боломжит Үлдэгдлээс олгож болох ба ийнхүү олгоход дараах зүйлсийг дагаж мөрдөнө. Үүнд:

#### **(a) Зээл Олгох Сүүлчийн Өдөр**


Зээлдэгч Боломжит Үлдэгдлээс хөрөнгө татах эрх нь Хүчин Төгөлдөр болох Өдөр нээгдэж, Зээл Олгох Сүүлчийн Өдөр, эсвэл үүнээс хойш, Зээлдэгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг (Батлан Даалтын Гэрээ байгуулах тохиолдолд уг хүсэлтэд Батлан Даагч гарын үсгээ зурсан байх) үндэслэн Банкнаас тогтоосон өөр өдөр дуусгавар болно. Банк ийнхүү өөр өдөр тогтоосон бол энэ тухай Зээлдэгчид шуурхай мэдэгдэнэ.

#### **(b) Зээл Татан Авалтыг хүссэн өргөдөл**

- (i) Зээлийг авч ашиглахын тулд Зээлдэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч (эсвэл уг Төлөөлөгчийн томилсон этгээд) Зээл Татан Авалтыг хүссэн өргөдлийг Банкинд ирүүлнэ. Зээл Татан Авалтыг хүссэн өргөдлийг ЕСБХБ-ны Зээлийн Журамд заасан журам, хэлбэрийн дагуу, өргөдөлд заасан Зээл Татан Авалтын өдрөөс 15 (арван тав)-аас доошгүй хоногийн өмнө Банкинд ирүүлнэ. Зээл Татан Авалтыг хүссэн өргөдөл нь Банкнаас тавьсан агуулгын шаардлагыг хангасан байх ба Зээлдэгч нь Зээл Татан Авалтын өргөдөлд заасан дүнг зээлэх эрхтэй ба тухайн мөнгөн дүнг Зээлийн хэлэлцээрт заасан зориулалтын дагуу зарцуулахыг нотолсон, Банкнаас тавьсан агуулга, хэлбэрийн шаардлагад нийцсэн зохих баримт бичиг, бусад нотлох баримтыг өргөдөлд хавсаргана.
- (ii) Хамгийн сүүлийн Зээл Татан Авалт бусад (эсвэл Банкнаас өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд) аливаа Зээл Татан Авалтын дүн Зээл Татан Авалтын Доод Хэмжээнээс багагүй байна.

#### **(c) Зээл Татан Авалтын Валют**

Зээл Татан Авалтыг Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх зардлуудтай тэнцүү хэмжээгээр, Зээлийн Валютаар хийнэ. Тухайн зардлыг Зээлийн Валютаас өөр Валют (эсвэл Валютууд)-аар төлөх тохиолдолд үүнд зориулах Зээлийн Татан Авалтын хэмжээг дараах байдлаар тодорхойлно:



- (i) Хэрэв Зээлдэгч төлбөрийг Зээлийн Валютаар хийхийг хүссэн тохиолдолд Банк Зээл Татан Авалтын хэмжээг төлбөр хийхээс хоёр Ажлын Өдрийн өмнө тодорхойлно.
  - (ii) Хэрэв Зээлдэгч төлбөрийг тухайн зардлын Валют (эсвэл Валютууд)-аар хийхийг хүсэж, тухайн зардлыг ЕСБХБ-ны Гишүүний зах зээлээс худалдан авч болох Валютаар илэрхийлсэн нөхцөлд Банк тухайн зардлын Валют (эсвэл Валютууд)-ыг өөрийн сонгосон арга хэлбэрээр худалдан авна. Банк Зээл Татан Авалтын хэмжээг тодорхойлохдоо өргөдөлд заасан хүсэлтийг биелүүлэхийн тулд Зээлийн Валютыг ашиглан өөр валют худалдан авахад гарсан, эсвэл гарах байсан (ханшийн) зардлыг үндэслэнэ.
- (d) Өөр Валютаар илэрхийлсэн төлбөр гүйцэтгэх


Онцгой тохиолдолд Банк Зээлдэгчийн хүсэлтийг зөвшөөрч, Зээлийн Валют, эсвэл зардлын валютаас өөр Валют (эсвэл Валютууд)-аар төлбөр хийж болно. Ийм тохиолдолд Банк тухайн Валют (эсвэл Валютууд)-ыг өөрийн сонгосон арга хэлбэрээр худалдан авна. Банк Зээл Татан Авалтын хэмжээг тодорхойлохдоо өргөдөлд заасан хүсэлтийг биелүүлэхийн тулд Зээлийн Валютыг ашиглан өөр валют худалдан авахад гарсан, эсвэл гарах байсан (ханшийн) зардлыг үндэслэнэ.

### 3.02 дахь Хэсэг. Нөхцөлт ба Нөхцөлт Бус Нөхөн Төлөх Үүрэг

- (a) Зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн, Зээлээр санхүүжүүлэхээр заасан, аккредитивын нөхцөлийн дагуу арилжааны банкнаас төлсөн зардлыг Банк нөхөн төлөхөөр ЕСБХБ-ны Зээлийн Журамд заасны дагуу нөхцөлт, эсвэл нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэг хүлээж болно. Ийнхүү гүйцэтгэсэн нөхөн төлбөрийг Зээл Татан Авалтад тооцно.
- (b) Нөхцөлт Нөхөн Төлөх Үүргийн хувьд тухайн Зээлийг 7.01, эсвэл 7.02 дахь Хэсэгт заасны дагуу түр зогсоосон, эсвэл цуцалсан тохиолдолд Банкны нөхөн төлөх үүрэг мөн адил түр зогссон, эсвэл цуцлагдсанд тооцно.
- (c) Нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүргийн хувьд Банк нөхөн төлөх үүргээ тухайн Зээлийг түр зогсоох, эсвэл цуцлах эсэхээс үл хамааран биелүүлнэ.

### 3.03 дахь Хэсэг. Зээлийн Хөрөнгийг Дахин Хуваарилах

- (a) Хэрэв аль нэг Зардлын Ангилалд зориулж төсөвлөсөн Зээлийн хэмжээ нь тухайн Зардлын Ангилал доторх зардлуудыг анх хувилсан хэмжээнд бүрэн санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй гэж Банк үзвэл Зээлдэгчид (хэрэв Зээлийн хэлэлцээрээс гадна Батлан Даалтын Гэрээг байгуулсан бол мөн Батлан Даагчид) мэдэгдэх замаар дараах арга хэмжээг авч болно:




- (i) дахин хуваарилахаас өмнө өөр Зардлын Ангилалд төсөвлөсөн, гэхдээ уг Ангиллын зардлуудыг санхүүжүүлэх шаардлагагүй гэж Банк үзсэн тохиолдолд дутагдал бүхий Зардлын Ангиллын дутагдаж буй дүнг нөхөхөд шаардлагатай хэмжээгээр дахин хуваарилах;
- (ii) хэрэв ийнхүү дахин хуваарилсан Зээлийн хөрөнгө дутагдаж буй дүнг бүрэн нөхөж чадахгүй тохиолдолд, тухайн Ангилал дахь бүх зардлыг төлж барагдуулах хүртэл уг Ангилалд зориулсан дараа дараагийн Зээл Татан Авалтыг олгох үүднээс санхүүжүүлэх зардлуудын хувийг бууруулах.
- (b) Дээрх (a)(i) заалтын дагуу дахин хуваарилах тохиолдолд Зээлдэгч Банктай харилцан тохиролцсоны үндсэн дээр Зээлийн хэсгээс зохих дүнг өөр Зардлын Ангилалд нэмж дахин хуваарилахаар Банкинд хүсэлт гаргаж болно (хэрэв Зээлийн хэлэлцээрээс гадна Батлан Даалтын Гэрээг байгуулсан бол Батлан Даагч уг хүсэлтэд мөн гарын үсэг зурах буюу бусад хэлбэрээр хүсэлтийг батламжилна).

### 3.04 дэх Хэсэг. Хүү

3.09 дахь Хэсэгт зааснаас бусад тохиолдолд дараах заалтуудыг дагаж мөрдөнө:

- (a) Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд доорх 3.04(b) заалтын хувьд Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувь үйлчилнэ.
- (b) Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн хүүг дараах байдлаар тодорхойлж, төлнө:
- (i) Зээлдэгчийн авч хэрэглэсэн бөгөөд эргэн төлөгдөөгүй байгаа Зээлийн үндсэн дүнд тухайн Хүү Тооцох Мөчлөгийн турш Хувьсагч Хүүгийн Хувиар, энэхүү Хэсэгт заасны дагуу хүү тооцно.
- (ii) Хүүг
- Хүү Тооцох Мөчлөгийн эхний өдрөөс эхлэн (эхний өдрийг оруулж тооцно) сүүлчийн өдөр хүртэлх хугацаа (сүүлчийн өдрийг хасч тооцно)-ны турш өдөр бүр тооцно,
  - 1 (нэг) жилийг 360 хоног гэж үзэн, өнгөрсөн бодит хоногийн тоонд үндэслэж тооцож
  - тухайн Хүү Тооцох Мөчлөгийн сүүлийн өдөрт тохиох Хүү Төлөх Өдөр
- төлнө.
- (iii) Хувьсагч Хүүгийн Хувь нь Маржин ба (3.13 дахь Хэсэгт зааснаас бусад тохиолдолд) Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийн нийлбэртэй тэнцүү байна.
- (iv) Банк Хувьсагч Хүүгийн Хувь хамаарах Зээлийн хүүгийн хувийг Зээлийн хэлэлцээрийн дагуу тодорхойлох боломжтой болмогц тухайн Хүү Тооцох



Мөчлөгийн Хувьсагч Хүүгийн Хувь хамаарах Зээлд төлөх ёстой буюу төлөх хуваарьтай нийт дүнг тодорхойлж, Зээлдэгч ба Батлан Даагчид шуурхай мэдэгдэнэ.

(v) Энэ Хэсэгт Банкнаас Зээлдэгч эсвэл Батлан даагчид Ажлын Өдөр биш өдөр ямар нэгэн мэдэгдэл өгөхийг шаардахгүй.

(с) Дээрх заалтыг үл харгалзан, Зээлийн хэлэлцээрт заасан бол Зээлдэгч төлөгдөөгүй байгаа Зээлийн бүх, эсвэл зарим үлдэгдэлд Хувьсагч Хүүгийн Хувиар хүү төлөхийн оронд Тогтмол Хүүгийн хувиар хүү төлөхөөр шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд дараах заалтуудыг дагаж мөрдөнө:

(i) Зээлдэгч дээрх шийдвэрийг зөвхөн дараах тохиолдолд л гаргаж болно:


(A) ийнхүү шийдвэр гаргах үед 7.01 Хэсэгт заасан нөхцөл байдал үүсээгүй (ба ийм нөхцөл байдалд хүргэж болох үйл явдал гараагүй) ба Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болоогүй; ба

(B) ийнхүү Хувьсагч Хүүгийн Хувиас Тогтмол Хүүгийн Хувьд хөрвөж буй Зээлийн үндсэн дүн нь 5,000,000 Евро буюу түүнтэй тэнцэх хэмжээнээс багагүй байх.

(ii) Зээлдэгч өөрийн сонгосон Тогтмол Хүүгийн Хувийг Тодорхойлох Өдрөөс 5-аас доошгүй Ажлын Өдрийн өмнө энэ тухай Банкинд мэдэгдэх замаар дээрх шийдвэрийг гаргана. Энэхүү мэдэгдэл нь (Банк тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд) эргэлт буцалтгүй байх бөгөөд Зээлдэгчийн өөрийн сонгосон Тогтмол Хүүгийн Хувийг Тодорхойлох Өдөр, Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Мөчлөг, түүнчлэн Тогтмол Хүүгийн Хувьд хөрвөх Зээлийн дүнг тус тус харуулсан байна.

(iii) Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Өдрөөс эхлэн ийнхүү хөрвүүлсэн (ба Зээлдэгчийн мэдэгдэлд заасан) Зээлийн дүнд Тогтмол Хүүгийн Хувиар хүү тооцно. 3.04(d) Хэсэгт заасан Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийн тухайд - тухайн Тогтмол Хүүгийн Хувь руу Хөрвөх Мөчлөгийн тухайн Тогтмол Хүүгийн Хувийг Тодорхойлох Өдрийн байдлаар хүүгийн свопын зах зээлээс Банкны худалдан авч болох, Зээлийн Валютад хамаарах тогтмол форвард хүүгийн хувийг баримтлах ба (ингэхдээ, Зээлийн Тохируулгын Зөрүү (хамаарах бол), Зээлийн үндсэн дүн ба хүүгийн эргэн төлөлтийн хуваарь зэрэг Зээлийн тухайн хэсэгт хамаарах нөхцөлийг харгалзана) Зээлдэгчийн санхүүгийн чадавхаас хамааран үүнд (Зээлийн үндсэн дүн, хүү) өөрчлөлт оруулж болно. Банк ийнхүү тухайн Тогтмол Хүүгийн Хувийг Тодорхойлох Өдөрт багтаан Тогтмол Хүүгийн хувийг тодорхойлж, Банк, Батлан Даагчид шуурхай мэдэгдэнэ.

(iv) Банк Зээлийн хэсгүүдэд хамаарах бүх Тогтмол Хүүгийн Хувиудыг нэг Тогтмол Хүүгийн Хувьд хэдийд ч нэгтгэж болох ба ба ийнхүү нэгдмэл Тогтмол Хүүгийн Хувь нь өмнөх Тогтмол Хүүгийн Хувиудын жигнэсэн дундажтай тэнцүү байна.





Банк ийнхүү нэгдмэл Тогтмол Хүүгийн Хувийг тодорхойлж, Зээлдэгчид шуурхай мэдэгдэнэ. Энэхүү нэгдмэл Тогтмол Хүүгийн Хувийг Тогтмол Хүүгийн Хувиудаар хүү тооцож байсан Зээлийн бүхий л үлдэгдэл дүнд, Банкнаас Зээлдэгчид ийнхүү мэдэгдсэнээс хойших Хүү Төлөх Өдрөөс эхлэн мөрдөнө.

(d) Тогтмол Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн хүүг дараах байдлаар тодорхойлж, төлнө:

(i) Зээлдэгчийн авч хэрэглэсэн бөгөөд эргэн төлөгдөөгүй байгаа Зээлийн үндсэн дүнд тухайн Хүү Тооцох Мөчлөгийн турш Тогтмол Хүүгийн Хувиар, энэхүү Хэсэгт заасны дагуу хүү тооцно.

(ii) Хүүг

- Хүү Тооцох Мөчлөгийн эхний өдрөөс эхлэн (эхний өдрийг оруулж тооцно) сүүлчийн өдөр хүртэлх хугацаа (сүүлчийн өдрийг хасаж тооцно)-ны турш,
- 1 (нэг) жилийг 360 хоног гэж үзэн, өнгөрсөн бодит хоногийн тоонд үндэслэж тооцож,
- тухайн Хүү Тооцох Мөчлөгийн сүүлийн өдөрт тохиох Хүү Төлөх Өдөр

төлнө.


(iii) Тогтмол Хүүгийн Хувь нь Маржин ба Зээлийн хэлэлцээрт(хэрэв Тогтмол Хүүгийн Хувийг 3.04(с) Хэсгийн дагуу Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш тодорхойлсон бол 3.04(с)(iii) Хэсэгт заасны дагуу Банкнаас Зээлдэгч, Батлан Даагчид ирүүлсэн мэдэгдэлд) заасан Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийн нийлбэртэй тэнцүү байна.

(e) Хэрэв 7.01, эсхүл 7.06 дахь заалтуудад заасан нөхцөл байдал үүсэж, үргэлжилсээр байгаа бол тухайн Зээлийн дүнд ногдох хүүг Тогтмол Хүүгийн Хувиар төлөх ёстой байсан ч гэсэн Тогтмол Хүүгийн Хувиар биш, үүний оронд Хувьсагч Хүүгийн Хувиар тооцож төлөхийг Банкны зүгээс Зээлдэгчээс шаардаж болно.

(f) Зээлд тооцох хүүгийн хэмжээг Банкнаас тогтоосон шийдвэр бүр Зээлдэгчийн хувьд эцсийн, шийдвэрлэх бөгөөд заавал биелүүлэх шинжтэй байна.

### 3.05 дахь Хэсэг. Үүргийн Шимтгэл ба Зээл Олгосны Шимтгэл

(a) Зээлдэгч Банкинд үүргийн шимтгэлийг Зээлийн хэлэлцээрт заасан хувиар төлнө. Үүргийн Шимтгэлийн хэмжээг (i) Боломжит Үлдэгдлийн дүн ба (ii) Нөхөн Төлөх Үүрэгт хамаарч, тухайн үеийн байдлаар Зээлдэгчид олгоогүй Зээлийн хэсгийн нийлбэрт ногдуулж тооцох бөгөөд нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэгт хамаарах Зээлийн хэсэгт ногдох Үүргийн Шимтгэлийн хэмжээ нь Зээлийн хэлэлцээрт заасан Үүргийн Шимтгэлийн хувиас жилийн 0,5%-иар илүү байна. Үүргийн Шимтгэлийг Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 60 (жар) дахь хоногоос эхлэн тооцох (нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэгт хамаарах Зээлийн хэсгийн хувьд Үүргийн Шимтгэлийг тухайн





нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүргийг хүлээсэн өдрөөс эхлэн тооцох) ба түүний хэмжээг 3.04(b)(ii) Хэсэгт заасан хүүг тооцох аргачлалаар тогтооно. Үүргийн Шимтгэлийг Хүчин Төгөлдөр Болох Өдрөөс хойш, анхны Хүү Төлөх Өдрөөс эхлэн Хүү Төлөх Өдөр бүр (тухайн өдөр хүү төлөхгүй байхаар байсан ч) төлнө.


- (b) Зээлдэгч Зээлийн үндсэн дүнгийн 1 (нэг) хувьтай тэнцүү хэмжээ (эсвэл Зээлийн хэлэлцээрт заасан өөр хэмжээ)-ний зээл олгосны шимтгэлийг Банкинд төлнө
- (c) Зээлийн хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Банк Зээлдэгчийн нэрийн өмнөөс, Хүчин Төгөлдөр Болох Өдөр (эсвэл үүнээс хойш 7 хоногийн өдөр) Боломжит Үлдэгдлээс 3.05(b) Хэсэгт заасан Зээл Олгосны Шимтгэлийн дүнг суутгаж, өөртөө авна.
- (d) Хэрэв Зээлдэгч Зээл Олгосны Шимтгэлийг өөрийн эх үүсвэрээс төлөхөөр Зээлийн хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэсэн тохиолдолд Зээл Олгосны Шимтгэлийг Хүчин Төгөлдөр Болох Өдрөөс хойш 7 хоногийн өдөр дотор төлнө.

### 3.06 дахь Хэсэг. Зээлдэгчийн Төлбөрүүд

- (a) Зээлдэгч Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийг Зээлийн хэлэлцээрт заасан хугацаанд, мөн Гэрээнд заасан журмын дагуу төлөх үүрэгтэй.
- (b) Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн төлөх ёстой буюу төлөх ёстой болсон хуримтлагдсан хүү, шимтгэл, хураамжийн нийлбэр дүнг зуутын орон хүртэл тоймлоно.

### 3.07 дахь Хэсэг. Зээлийг Хугацаанаас Өмнө Төлөх

- (a) Зээлдэгч авч хэрэглэсэн ба эргэн төлөөгүй байгаа Зээлийн үндсэн дүнг түүнд ногдох хуримтлагдсан бөгөөд төлөөгүй байгаа хүү, Шимтгэлүүдийн хамт Банкинд 30 (гуч)-аас доошгүй Ажлын Өдрийн өмнө бичгээр мэдэгдэж, хугацаанаас нь өмнө аль ч Хүү Төлөх Өдөр төлж болно. Зээлдэгч энэхүү мэдэгдлээ цуцалж үл болох бөгөөд заавал биелүүлнэ.
  - (b) Зээлдэгч ийнхүү Зээлийг хугацаанаас нь өмнө төлөхдөө тухайн Зээлийн үндсэн дүнгийн 0,125 хувьтай тэнцүү хэмжээний хугацаанаас өмнө төлсний шимтгэлийг Банкинд төлөх үүрэгтэй.
  - (c) Зээлийг хугацаанаас нь өмнө хэсэгчлэн төлөх тохиолдолд:
    - (i) Ийнхүү хугацаанаас нь өмнө төлж буй Зээлийн дүн нь Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд дор хаяж:
      - (A) Хугацаанаас Өмнө Төлөх Доод Хэмжээ, эсвэл
      - (B) авч хэрэглэсэн ба эргэн төлөөгүй байгаа Зээлийн үндсэн дүн
- хоёрын аль багатай тэнцүү байх ба



(ii) дарааллын хувьд:

- (А) нэгдүгээрт, Зээлийн хүү, Шимтгэлүүдийг төлж,
- (В) хоёрдугаарт, эргэн төлж буй Зээлийн үндсэн дүнг эргэн төлөх өөр өөр хугацаа бүхий хэд хэдэн Зээлийн хэсэгт хувь тэнцүүлэн төлсөнд тооцно.

### 3.08 дахь Хэсэг. Зээлийг Цуцлах

(a) Зээлдэгч 30 (гуч)-аас доошгүй Ажлын Өдрийн өмнө Банкинд бичгээр мэдэгдэж, Боломжит Үлдэгдлийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн аль ч Хүү Төлөх Өдөр цуцалж болно. Зээлдэгч энэхүү мэдэгдлээ цуцалж үл болох бөгөөд заавал биелүүлнэ. Ийнхүү цуцлах дүн нь дор хаяж:

(А) Зээл Цуцлах Доод Хэмжээ, эсвэл

(В) Боломжит Үлдэгдэл

хоёрын аль багатай тэнцүү байх ба


(b) Зээлдэгч дээрх (a) заалтад заасан, эсвэл Банк 7.02 дахь Хэсэгт заасны дагуу тус тус цуцалсан тохиолдолд:

- (i) Зээлдэгч цуцалсан өдрийн байдлаар төлөх ёстой боловч төлөөгүй бүхий л Шимтгэлүүдийг, мөн тухайн цуцалж буй Зээлийн үндсэн дүнгийн 0,125 хувьтай тэнцүү хэмжээний цуцалсны шимтгэлийг (7.02(a) Хэсэгт заасны дагуу цуцалснаас бусад тохиолдолд) уг цуцалсан өдөр Банкинд төлнө;
- (ii) Цуцалж буй Зээлийн дүнг ийнхүү цуцалсан өдрийн байдлаар буй Боломжит Үлдэгдлээс суутгах замаар хасна; болон
- (iii) Цуцалж буй Зээлийн дүнг цуцалсан өдрөөс хойш тохиох, Зээл эргэн төлөх өөр өөр хугацаа бүхий хэд хэдэн Зээлийн хэсэгт хувь тэнцүүлэх замаар Зээлийн үндсэн дүнгээс хасна.

### 3.09 дэх Хэсэг. Хугацаа Хэтэрсний Хүү

(a) Хэрэв Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх ёстой аливаа төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд ийнхүү хугацаа хэтэрсэн дүнд дараах нийлбэр хүүг тооцож төлүүлнэ:

- (i) жилийн хоёр хувь (2%);
- (ii) Маржин; ба



- (iii) Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувь, эсвэл Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болсон тохиолдолд Банкны өөрийн сонгосон эх сурвалжаас Зээлийг санхүүжүүлэхээр татсан эх үүсвэрийн өртгийг жилээр хувьчилж илэрхийлсэн хувь (эсвэл Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийг баримтлахаар Банк өөрөө шийдвэрлэсэн бол уг Хувь). Хэрэв энэхүү (iii) заалтын дагуу тооцсон хувь нь тэгээс бага байхаар бол уг хувийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

(b) Хугацаа Хэтрүүлсний Хүүг:

- (i) түүнийг төлөх ёстой өдрөөс эхлэн төлж барагдуулсан өдөр хүртэл, өдрөөр тооцож ногдуулна,
- (ii) 1 (нэг) жилийг 360 хоног гэж үзнэ, өнгөрсөн бодит хоногийн тоонд үндэслэж тооцно
- (iii) тухайн Хугацаа Хэтэрсний Хүү Тооцох Мөчлөг бүрийн сүүлийн өдөр нийлмэл хүү болгож тооцно.
- (iv) Шаардсан даруйд төлнө.
- (c) Хугацаа хэтэрсэн дүнд ногдох хүү болон Хугацаа Хэтэрсний Хүү Тооцох Мөчлөгийн хугацаа бүрийг Банк өөрөө тодорхойлох ба ийнхүү Банкны тодорхойлсон нь Зээлдэгчийн хувьд эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байна.


**3.10 дахь Хэсэг. [Зээлийн] Нөхцөлийн Өөрчлөлтийн Зардал**

- (a) Хэрэв Хувьсагч Зээлийн Хүүгийн Хувиар хүү тооцох Еврогоор илэрхийлсэн Зээлийн хэсгийг аливаа шалтгаанаар (7.06 дахь Хэсэг заасны дагуу Зээлийг түргэсгэж төлөх тохиолдлыг хамруулан) тухайн Хүү Тооцох Мөчлөгийн сүүлчийн өдөр биш, өөр өдөр төлөх болсон бол Зээлдэгч Банкны шаардлагаар Банкинд дараах мөнгөн дүнг (хэрэв байгаа бол) төлнө:

- (1) Зээлийн тухайн хэсгийн хувьд уг хэсгийг төлөх үүрэг үүссэн өдрөөс эхлэн Хүү Тооцох Мөчлөгийн сүүлийн өдөр хүртэл хугацаанд холбогдох Хүү Тооцох Мөчлөгийн Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувьтай тэнцүү хэмжээгээр хуримтлагдах байсан хүүгийн
- (2) Банк Зээлийн тухайн хэмжээтэй тэнцүү дүнг Евро бүсийн зах зээл дэх (Еврогийн хувьд) тэргүүлэгч банкинд Зээлийн тухайн хэсгийг төлөх үүрэг үүссэн өдрөөс эхлэн тухайн Хүү Тооцох Мөчлөгийн сүүлийн өдөр хүртэл хугацаатай тэнцүү хугацаагаар хадгаламж хэлбэрээр байршуулсан тохиолдолд Банкны олж авах байсан хүүгээс

хэтэрсэн дүн.

- (b) Зээлдэгч хэдийд ч 3.07 Хэсэгт заасны дагуу Хувьсагч Хүүгийн Хувь тооцох Ам.Доллараар илэрхийлсэн Зээлийн аль нэг хэсгийг хугацаанаас нь өмнө төлөх тухай



мэдэгдэл өгсөн, эсхүл Зээлдэгч Зээлийн дээр дурдсан хэсгийг сайн дураараа хугацаанаас нь өмнө төлсөн тохиолдолд хугацаанаас нь өмнө төлсний хураамж болон үүнтэй холбогдуулан төлөх бусад дүнгээс гадна хугацаанаас нь өмнө төлж буй Зээлийн үндсэн төлбөрийн тэг зууны арван таван хувь (0.15%)-тай тэнцэх хэмжээний буцаах шимтгэлийг Банкинд төлнө.

(с) Зээлийн хэлэлцээрийн хугацаанд:


- (1) Зээлдэгч 3.07 дахь Хэсэгт заасны дагуу Зээлийн аль нэг хэсгийг хугацаанаас нь өмнө төлөхөөр Банкинд мэдэгдсэн (бөгөөд Зээлийн уг хэсэгт Тогтмол Хүүгийн Хувиар хүү тооцох) тохиолдолд, эсвэл Зээлдэгч Зээлийн уг хэсгийг бусад байдлаар хугацаанаас нь өмнө төлсөн тохиолдолд;
- (2) Тогтмол Хүүгийн Хувиар хүү тооцох Зээлийн аль нэг хэсгийг 7.06 дахь Хэсэгт заасны дагуу түргэсгэж төлүүлэх болсон тохиолдолд, эсвэл бусад байдлаар Зээлийн хэлэлцээрт заасан хугацаанаас нь өмнө төлөх болсон тохиолдолд, эсвэл 3.04(е) дахь Хэсэгт заасны дагуу Хувьсагч Хүүгийн Хувиар тооцох болсон тохиолдолд; эсвэл
- (3) Тогтмол Хүүгийн Хувиар хүү тооцох Зээлийн аль нэг хэсгийг 3.08, 7.02, эсвэл 7.06 дахь Хэсэгт тус тус заасны дагуу цуцалсан тохиолдолд, эсвэл бусад байдлаар цуцалсан тохиолдолд;

Зээлдэгч нь хугацаанаас өмнө төлсний шимтгэл, цуцалсны шимтгэл, үүнтэй холбоотой өөр бусад шимтгэлийг төлөхөөс гадна Банкны шаардлагаар аливаа [Зээлийн] Нөхцөлийн Өөрчлөлтийн Зардлыг Банкинд төлөх үүрэгтэй. Хэрэв Нөхцөлийн Өөрчлөлтийн Зардлын дүн сөрөг утгатай байвал Банк дараагийн Хүү Төлөх Өдөрт тухайн Нөхцөлийн Өөрчлөлтийн Зардлын дүнг Зээлийн Валютаар кредитлэнэ.

Хүү тооцох Мөчлөг Хүү тооцох Мөчлөг Хүү тооцох Мөчлөг

(d) Зээлдэгч Банкнаас ирүүлсэн мэдэгдлийн хүлээн авмагц дараах нөхцөл байдлын улмаас Банкинд учирсан боловч 3.10(a), 3.10(b), 3.10(c) заалтуудад заасны дагуу Банкинд төлж барагдуулаагүй аливаа зардал, алдагдал, хохирлыг Банкинд нөхөн төлөх үүрэгтэй – үүнд, 7.01, эсвэл 7.06 дахь Хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн, 3.13(b) заалтад заасны дагуу аливаа холбогдох Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаанд өөрчлөлт орсон, 3.13(c) заалтад заасны дагуу хүүгийн хувийг бодох суурьд өөрчлөлт орсон, Зээлийн тухайн хэсгийг хугацаанаас нь өмнө эсвэл хугацаанд нь зохих Хүү Тооцох Мөчлөгийн сүүлийн өдөр биш, өөр төлсөн, Зээлдэгч аливаа төлбөрийг зохих хугацаанд нь төлж барагдуулаагүй, Банк Зээлийн хэлэлцээрийн аль нэг, эсвэл хэд хэдэн заалтын үйлчлэлийн улмаас 3.01(b) заалтын дагуу ирүүлсэн зээл олгох өргөдөлд хүссэн Зээл Татан Авалтыг гүйцэтгээгүй (Банкны буруу, эсвэл хайхрамжгүй байдлаас бусад шалтгаанаар), Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн аль нэг заалтын дагуу хүргүүлсэн, Хугацаа Хэтэрсний Хүү тооцох Мөчлөгийн сүүлийн өдрөөс өөр өдөр хугацаа хэтэрсэн дүнг төлсөн, Зээлийг хугацаанаас нь өмнө төлөх мэдэгдлийг ирүүлсэн боловч мэдэгдэлд заасны дагуу урьдчилан төлөөгүй.

(е) Зээлдэгч нь Банкинд илэрхий алдаатай болохыг Банкны шаардлагад нийцүүлэн нотолсноос бусад тохиолдолд 3.10 дахь Хэсэгт заасны дагуу төлөх аливаа дүнгийн талаар Банкнаас ирүүлсэн сертификат нь Зээлдэгчийн хувьд эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байна.



### 3.11 дэх Хэсэг. Төлбөрийн Валют, Хэлбэр, Хэмжээ

- (a) Зээлийн хэлэлцээр, эсвэл Батлан Даалтын Гэрээний дагуу Зээлдэгчээс Банкинд төлөх Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүд, бусад аливаа төлбөрийг Зээлийн Валютаар, зохих өдөрт гүйлгээг хийх замаар, Банкны заасан хаяг (эсвэл хаягууд)-аар, түүний нэр заасан банк (эсвэл банкууд)-аар аливаа суутгал, хасалтгүйгээр, тооцоо нийлэхээр, эсвэл сөрөг шаардлагад суутгалгүйгээр гүйцэтгэнэ.
- (b) Хэрэв Зээлийн хэлэлцээрийн дагуу аливаа төлбөрийг гүйцэтгэх өдөр Ажлын биш Өдөр тохиовол, уг төлбөрийг түүний дараагийн Ажлын Өдөрт гүйцэтгэх ба хүү (эсвэл тухайн нөхцөл байдлаас шалтгаалан Үүргийн Шимтгэл)-г тухайн өдрөөс эхлэн дараагийн Ажлын Өдөр хүртэлх хугацаанд тооцно. Зээлдэгчийн хүсэлтийг Банк зөвшөөрсөн тохиолдолд талуудын тохирсноор уг төлбөрийг үүнээс өмнөх аль нэг өдөр гүйцэтгэж болно.

### 3.12 дахь Хэсэг. Хураамж, Зардлууд

Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, аливаа Төслийн Гэрээ, холбогдох бусад баримт бичгийг бэлтгэх, үйлдэх, нөгөө талд хүргүүлэх, бүртгүүлэхэд Банкнаас гарсан аливаа мэргэжлийн зөвлөхүүдийн, банкны, шилжүүлгийн, валют солилцооны шимтгэл, зардлыг Зээлдэгч хариуцна.

### 3.13 дахь Хэсэг. Зах Зээл Тогтворгүйжих


- (a) Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болбол Банк энэ тухай Зээлдэгчид шуурхай мэдэгдэнэ. Банк Зээлдэгчид Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болсон тухай мэдэгдсэнээр

- (1) Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн хүүг дараах нийлбэр дүнгээр Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал дуусгавар болсон тухай Банкнаас Зээлдэгчид мэдэгдэх хүртэл бодож хуримтлуулна:

(A) Маржин; ба

- (B) Банкны өөрийн сонгосон эх сурвалжаас Зээлийг санхүүжүүлэхээр татсан эх үүсвэрийн өртгийг жилээр хувьчилж илэрхийлсэн хувь (эсвэл Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийг баримтлахаар Банк өөрөө шийдвэрлэсэн бол уг Хувь) ба үүнийг Банкнаас Зээлдэгчид нэн яаралтай, гэхдээ ямар ч тохиолдолд тухайн Хүү Тооцох Мөчлөгт ногдох Хүү Төлөх Өдрөөс өмнө мэдэгдвэл зохино. Хэрэв энэхүү (iii) заалтын дагуу тооцсон хувь нь тэгээс бага байхаар бол уг хувийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

түүнчлэн






- (2) Тогтмол Хүү Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн тухайн хэсэгт ногдох хүүг 3.04(d) заалтад заасны дагуу Тогтмол Хүүгийн Хувиар (Маржиныг оролцуулан) Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал дуусгавар болсон тухай Банкнаас Зээлдэгчид мэдэгдэх хүртэл бодож хуримтлуулна.
- (b) Хэрэв Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болсон тохиолдолд Банк нь аливаа холбогдох Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацааг Зээлдэгчид бичгээр мэдэгдэх замаар өөрийн хүсэл зоригийн дагуу өөрчлөх эрхтэй. Ийнхүү Хүү Тооцох Мөчлөгт оруулсан өөрчлөлт нь Банкны мэдэгдэлд заасан өдрөөс эхлэн хүчинтэй болно.
- (c) 3.13(a) заалтыг үл харгалзан, Зах Зээл Тогтворгүйжих Үйл Явдал бий болсон ба Банк, (эсвэл Зээлдэгч) шаардсан тохиолдолд 3.13(a) заалтад заасны дагуу Банкнаас мэдэгдэл хүргүүлснээс 5 (таван) Ажлын Өдрийн дотор Банк, Зээлдэгч хоёр тухайн Зээлийн хувьд мөрдөх хүүгийн хэмжээг тодорхойлох орлох суурийг харилцан тохиролцох зорилгоор хэлэлцээр хийнэ (гучаас илүүгүй хоногийн хугацаагаар). Ийнхүү харилцан тохиролцсон өөр суурь нь түүнд заасан журмын дагуу хүчинтэй болж, дээрх 3.13(a) заалтад заасан, тухайн үед хүчинтэй байсан хүүгийн хэмжээг орлоно. Талууд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Зээлдэгч нь дараагийн Хүү Төлөх Өдөрт Зээлийг 3.07 дахь Хэсэгт заасны дагуу бүхэлд нь хугацаанаас өмнө төлж болох ба энэ тохиолдолд хугацаанаас нь өмнө төлсний шимтгэлийг төлөхгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### 4.01 дахь Хэсэг. Хамтран Ажиллах, Мэдээлэл Солилцох

- (a) Банк, Зээлдэгч, Батлан Даагч, мөн Төсөл Хэрэгжүүлэгч бүр Зээлээр санхүүжих Төслийн зорилгод хүрэхийн тулд нягт хамтран ажиллах үүрэгтэй. Үүнтэй холбоотой Банк, Зээлдэгч, Батлан Даагч, мөн Төсөл Хэрэгжүүлэгч бүр нар дараах үүргийг хүлээнэ:
- (i) Нөгөө талын хүсэлтээр Зээлээр санхүүжиж буй Төслийн явц, талуудын Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээгээр тус тус хүлээсэн талаар үүргийн биелэлтийн талаар санал солилцох, түүнчлэн аливаа Төслийн Гэрээнд тал болон оролцож буй Төсөл Хэрэгжүүлэгчийн үүргийн биелэлт, бусад гэрээний биелэлтийн талаар санал солилцох, нөгөө талаас ирүүлсэн үндэслэл бүхий хүсэлтийн хариуд дээрхтэй холбоотой аливаа бусад мэдээллийг гаргаж өгөх;
- (ii) Дээрх (i) заалтын хүрээнд саад бэрхшээл учирсан, эсвэл учирч болзошгүй тохиолдолд нөгөө талд шуурхай мэдээлэх.
- (b) Зээлдэгч Төслийн агуулга, цар хүрээ, Төсөл Хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах санал, эсвэл Төслийн хэрэгжилт, Төсөл Хэрэгжүүлэгч, түүний үйл ажиллагаанд ноцтой нөлөөлж болох аливаа үйл явдал, нөхцөл байдлын талаар Банкинд шуурхай мэдэгдэнэ.






- (с) Батлан Даагч Төслийн хэрэгжилт, үйл явц, хэвийн ажиллагаа, Зээлдэгчийн Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн үүргийн биелэлт, Төсөл Хэрэгжүүлэгчийн Төслийн Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хөндлөнгөөс оролцох, саад тотгор учруулахуйц үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй ба өөрийн (Батлан Даагчийн) аливаа төлөөлөгч, хараат, эсвэл охин компанийн зүгээс ийм үйлдэл, үйл ажиллагаа мөн адил явуулахгүй байх явдлыг хангана. Батлан Даагчийн өмчийн эрх, удирдлага дор оршдог, эсвэл түүний өмнөөс буюу түүний эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг аливаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зүгээс ийм үйлдэл, үйл ажиллагааг мөн адил явуулахгүй байх явдлыг хангана.

#### 4.02 дахь Хэсэг. Төслийг Хэрэгжүүлэх Үүрэг

- (а) Зээлдэгч Төслийг хэрэгжүүлэхэд (эсвэл бусад этгээд Төслийг хэрэгжүүлэхэд) Зээлийн хэлэлцээр, холбогдох бусад дүрэм, журам, стандартад заасан байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, бусад шаардлагад нийцүүлэн, өндөр бүтээмжийг ямагт зорьж, хичээл зүтгэл гаргах ба шаардлагатай бол мөнгө хөрөнгө, газар, оффис, үйлчилгээ, бусад нөөцийг шуурхай гаргана.
- (b) Аль нэг Төсөл Хэрэгжүүлэгч Төслийн хэрэгжилтийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн хариуцахаар Төслийн Гэрээнд заасан бол Зээлдэгч дараах үүргийг хүлээнэ:
- (i) тухайн Төсөл Хэрэгжүүлэгчийг Төслийн Гэрээнд заасан үүргээ уг Гэрээнд заасны дагуу биелүүлэх явдлыг хангах;
- (ii) ийнхүү үүргээ биелүүлэхэд нь өөрөө, эсвэл бусдын зүгээс хөндлөнгөөс оролцох, саад тотгор учруулахуйц үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх.
- (с) Дээрх (а), (b) заалтуудын ерөнхий байдлыг үл хязгаарлан, Зээлдэгч нь Төслийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай газар, газрын эрхийг олж авахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авч, ийм газар, газрын эрхийг Төслийн зорилгоор авсан болохыг Банкнаас хүсэлт ирүүлсэн бол Банкны шаардлагад нийцсэн нотлох баримтыг түүнд гаргаж өгнө.
- (d) Зээлдэгч дараах даатгалыг хийлгэх, эсвэл Банкны шаардлагад нийцсэн байдлаар ийнхүү даатгах шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй:
- (i) Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх импортын бараа бүтээгдэхүүний хувьд – худалдан авалт, ашиглалт буюу суурилуулалтын цэг хүртэлх тээвэрлэлт, хүргэлттэй холбоотой эрсдэл (болон шаардлагатай бол барилгын явц дахь эрсдэл)-ийн эсрэг даатгал ба уг даатгалын дагуу хийх нөхөн төлбөрийг тухайн бараа бүтээгдэхүүнийг солих, засварлахад шаардлагатай Валютаар хийх;
- (ii) Зээлдэгчийн өмчлөл, эсвэл хяналтад байж, Төслийн санхүү болон технологийн байдалд нөлөөлөх бусад бүхий л эд зүйлсийн даатгал.



- (e) Зээлдэгч нь Төсөлтэй холбоотой аливаа эд хөрөнгө, барилга байгууламжийн хэвийн ашиглалт, үйлчилгээг ямагт хангаж, шаардлагатай бүхий л засвар, шинэчлэлийг шуурхай гүйцэтгэх буюу хангана.
- (f) Зээлдэгч нь Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх аливаа эд хөрөнгө, ажил, үйлчилгээг гагцхүү Төслийн зорилгоор л ашиглах үүрэгтэй.
- (g) Зээлдэгч, Батлан Даагч, мөн Төсөл Хэрэгжүүлэгч бүр Төслийн худалдан авалт, аливаа гэрээ хэлцэл байгуулах, эрх олгох явцад (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) Хориглосон үйл ажиллагааг явуулахгүй, түүнчлэн өөр өөрсдийн албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий ажилтан, Хамаарал бүхий этгээд, агент, төлөөлөгч нарыг ч Хориглосон үйл ажиллагааг явуулахгүй байх нөхцөлийг хангах үүрэгтэй.

#### 4.03 дахь Хэсэг. Худалдан Авалт


(a) Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Төсөлд шаардлагатай, Зээлээр санхүүжих аливаа бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ЕСБХБ-ны Худалдан Авалтын Журам ба Зээлийн хэлэлцээрт тус тус заасны дагуу явуулна.

(b) Хэрэв Зээлдэгч, Батлан Даагч, аливаа Төсөл Хэрэгжүүлэгч, ханган нийлүүлэгч, тэдгээрийн гэрээлэгч, гүйцэтгэгч, дэд гүйцэтгэгч, концесс (эрх) эзэмшигч, зөвлөх, дэд зөвлөх нь Төсөлтэй холбоотойгоор аливаа гэрээг байгуулах эрхийн төлөө өрсөлдөх, эсвэл нэгэнт байгуулсан гэрээг биелүүлэх явцад явцад (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журамд заасан Хориглосон үйл ажиллагааг явуулсан болохыг тогтоосон бол Банк Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журамд заасан Албадан Хэрэгжүүлэх, Нийтэд Мэдээлэх гэсэн арга хэмжээг авах эрхтэй.

(c) Зээлдэгч, Батлан Даагч, Төсөл Хэрэгжүүлэгч тус бүр нь Зээлийн хэлэлцээрт зааснаар, өөр өөрсдийн хариуцах Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд тухайн Төсөлтэй холбоотой тендер баримт бичиг болон Төсөлтэй холбоотой аливаа гэрээнд (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) дараах зүйл заалтыг тусгах үүрэгтэй:

(i) ханган нийлүүлэгч, тэдгээрийн гэрээлэгч, гүйцэтгэгч, дэд гүйцэтгэгч, концесс (эрх) эзэмшигч, зөвлөх, дэд зөвлөх нь Төслийн хүрээнд Хориглосон үйл ажиллагааг явуулахгүй, түүнчлэн өөр өөрсдийн албан тушаалтан, ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий ажилтан, Хамаарал бүхий этгээд, агент, төлөөлөгч нарыг ч Хориглосон үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрөхгүй буюу хориглох тухай (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана),

(ii) Аль нэг этгээд Төсөлтэй холбогдуулан Хориглосон үйл ажиллагаа явуулсан (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) гэх үндэслэл байх тохиолдолд Банк Албадан



Хэрэгжүүлэх Бодлого, Журмыг удирдлага болгон, түүнд заасан Албадан Хэрэгжүүлэх, Нийтэд Мэдээлэх болон бусад арга хэмжээг авах эрхтэй болохыг ханган нийлүүлэгч, тэдгээрийн гэрээлэгч, гүйцэтгэгч, дэд гүйцэтгэгч, концесс (эрх) эзэмшигч, зөвлөх, дэд зөвлөх нарт мэдэгдэх тухай.

#### 4.04 дэх Хэсэг. Төслийн Тайлан, Баримт Бичгүүд

(а) Зээлдэгч, Батлан Даагч болон Төсөл Хэрэгжүүлэгч нь Төслийн өөр өөрсдийн шууд хариуцах бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд Зээлийн хэлэлцээрт заасны дагуу:

(i) Төслийн явц, үр дүнг (Төслийн зардал, үр ашгийг оруулан) баримтжуулж мониторинг хийх, Зээлээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг тайлан тооцоонд тусгах, тэдгээрийн Төслийн хүрэн дэх ашиглалт, хэрэглээг тайлагнахад чиглэсэн шаардлагатай албан хэрэг хөтлөлтийн журам, зааврыг нэвтрүүлж мөрдүүлэх ба Банкнаас хүсэлтээр Банкны төлөөлөгч этгээдийг холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангах үүрэгтэй;


(ii) (1) Банкны зүгээс Төсөлд үнэлгээ, мониторинг хийх, Төсөлтэй холбоотой IPAM-д гаргасан хүсэлтийг шалгах, шийдвэрлэх, (2) Төсөлтэй холбоотойгоор Хориглосон үйл ажиллагааг явуулсан эсэхийг шалгаж тогтоох зорилгоор (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) Банкны зүгээс үе үе хүсэх мэдээллийг Банкинд шуурхай гаргаж өгөх ба Банкнаас хүсэлтээр Банкны төлөөлөгчийг дараах боломжоор хангах үүрэгтэй:

(A) Төслийн, эсвэл Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн хэн алины үйл ажиллагаагаа явуулдаг өөр бусад байршил, барилгын талбайд нэвтрэх, барилгын явцтай танилцах;

(B) Зээлээр санхүүжих аливаа бараа, ажил, үйлчилгээ, түүнчлэн Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн аливаа үйлдвэр, барилга байгууламж, барилгын талбай, ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмж, хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл баримт бичиг, албаны бусад баримт бичиг, тайлан тооцоотой тус тус үзэж танилцах, Банкны томилсон аудиторт гаргаж өгөх;

(C) Банкны тавьсан шаардлагын дагуу Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн холбогдох төлөөлөгч, ажилтантай уулзах;

(iii) дээрх 4.04(a)(i), 4.04(a)(ii) хэсгүүдэд заасан заалтуудыг Төсөлтэй холбоотой тендер баримт бичиг болон Төсөлтэй холбоотой аливаа гэрээнд (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) ханган нийлүүлэгч, тэдгээрийн гэрээлэгч, гүйцэтгэгч, дэд гүйцэтгэгч, концесс (эрх) эзэмшигч, зөвлөх, дэд зөвлөх нарт хамааруулан заавал тусгах үүрэгтэй.




- (iv) Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Төсөлтэй холбоотой дээрх аливаа баримт бичиг, тайлан тооцоог Банкны төлөөлөгчид гаргаж өгөх, үүнд Төслийн байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал, Төслийн зардал, үр ашиг, Зээлийн зарцуулалт, Зээлээр санхүүжүүлсэн бүхий л бараа, ажил, үйлчилгээний тухай болон бусад шаардлагатай мэдээллийг тусгах;
  - (v) Дээрх (a)(iii) заалтын ерөнхий байдлыг үл хязгаарлан, Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд тайлант хугацаанд гарсан ахиц дэвшил, учирсан хүндрэл бэрхшээл, эдгээр хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга зам, авсан арга хэмжээ, дараагийн тайлант хугацаанд авах арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх санал, төлөвлөгөө болон бусад мэдээллийг агуулсан Төслийн тайлант Банкны шаардлагад нийцсэн хэлбэрээр гаргаж, Зээлийн хэлэлцээрт заасан тогтмол хугацаанд Банкинд ирүүлэх;
  - (vi) Төслийн төлөвлөгөө, техник болон бусад үзүүлэлт, тайлан, гэрээ хэлцэл, барилгын ажлын хуваарь, худалдан авалтын хуваарь, эдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Банкнаас ирүүлсэн үндэслэл бүхий хүсэлтийн дагуу зохих нарийвчлалтайгаар бэлтгэж, бэлтгэсэн даруйд шуурхай Банкны төлөөлөгчдөд ирүүлэх.
- (b) Зээлээр санхүүжих бараа, ажил, үйлчилгээг худалдан авсны дараа тухайн худалдагчийн нэр, иргэншил, гэрээний (худалдан авсан) үнийн мэдээллийг Банк нийтэд зарлаж болно.
- (c) Зээлдэгч:
- (i) Төслийг хэрэгжүүлж дууссаны дараа; эсвэл
  - (ii) Зээлийн бүх дүнг Зээлдэгчид олгосон, эсвэл цуцалсны дараа, гэхдээ ямар ч тохиолдолд Зээл Олгох Сүүлчийн Өдрөөс (эсвэл Банкнаас өөр өдрийг зөвшөөрсөн бол тухайн өдрөөс) хойш зургаан сарын дотор;

Банкны шаардлагад нийцсэн хэлбэрээр, Банкнаас ирүүлсэн үндэслэл бүхий хүсэлтийн дагуу зохих нарийвчлал бүхий, Төслийн хэрэгжилт, түүний эхний үеийн үйл ажиллагааны тухай тайланг байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал, Төслийн зардал, үр ашиг, Зээлийн зарцуулалт, Зээлдэгч ба Банкны хэн алины Зээлийн хэлэлцээрээр хүлээсэн өөр өөрсдийн үүргийн гүйцэтгэл, Зээл зорилгоо биелүүлсэн эсэх болон бусад мэдээллийг тусган шуурхай бэлтгэж Банкинд ирүүлнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ

### 5.01 дахь Хэсэг. Гуравдагч Талд Давуу Байдал Үл Үүсгэх

- (a) ЕСБХБ-ны Гишүүний Зээлээс бусад аливаа Гадаад Өр нь тухайн Гишүүний өмчлөл, эсвэл хяналтад байдаг гадаад валютын хуваарилалт, арилжаа, зарцуулалтын хувьд






Зээлээс давуу эрх эдлэх явдлыг гаргахгүй байх үүрэгтэй. Хэрэв аливаа Гадаад Өрийг хангахаар Төрийн Өмчийн хувьд Барьцааны Эрхүүдийг бий болгож, улмаар тухайн Гадаад Өрийн зээлдүүлэгч нь гадаад валютын хуваарилалт, арилжаа, зарцуулалтын хувьд давуу эрх эдлэх, эсвэл эдэлж болзошгүй байвал Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн Барьцааны Эрхүүд [Банкнаас Зээлдэгчид олгосон] Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн эргэн төлөлтийг *ipso facto* (ба Банкинд ямар ч зардал ногдохгүйгээр) хувь тэнцүү, эн зэрэгцээ дарааллаар хангах үүрэг үүсэх ба ЕСБХБ-ны Гишүүн нь тухайн Барьцааны Эрхүүдийг олгох, эсвэл зөвшөөрөхдөө энэ тухай тодорхой заалтыг гэрээнд заавал тусгана. Хэрэв ЕСБХБ-ны Гишүүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аливаа нэгжийн Хөрөнгөд хамаарах Барьцааны Эрхүүдийн хувьд ийм заалтыг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн улмаас гэрээнд тусгах боломжгүй бол ЕСБХБ-ны Гишүүн нь бусад Төрийн Өмчид хамаарах, Банкны шаардлагад нийцсэн, адил нөхцөл бүхий Барьцааны Эрхүүдийг нэн даруй (ба Банкинд ямар ч зардал ногдохгүйгээр) Банкинд олгох замаар Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн эргэн төлөлтийг хангана.

- (b) Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Зээлдэгч (ЕСБХБ-ны гишүүн биш) дараах үүргийг хүлээнэ:
- (i) Зээлдэгч аливаа өрийн үүргийг хангахаар өөрийн аливаа Хөрөнгийн хувьд Барьцааны Эрхүүдийг бий болгосон тохиолдолд ийнхүү бий болгосон Барьцааны эрхүүд нь [Банкнаас Зээлдэгчид олгосон] Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн эргэн төлөлтийг хувь тэнцүү, эн зэрэгцээ дарааллаар хангах ба энэ тухай тодорхой заалтыг гэрээнд (Банкинд ямар ч зардал ногдохгүйгээр) заавал тусгана;
  - (ii) Аливаа өрийн үүргийг хангахаар Зээлдэгчийн аливаа хөрөнгийн хувьд хуульд зааснаар Барьцааны Эрхүүд үүссэн тохиолдолд [Банкнаас Зээлдэгчид олгосон] Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн эргэн төлөлтийг Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн эргэн төлөлтийг хангах, адил нөхцөл бүхий өөр Барьцааны Эрхүүдийг (Банкинд ямар ч зардал ногдохгүйгээр) Банкинд олгоно.
- (c) Дээрх (b) заалтад заасан Зээлдэгчийн үүргүүд нь дараах Барьцааны Эрхүүдэд үл хамаарна:
- (i) Эд хөрөнгө худалдан авах үеэр худалдан авсан үнийг төлөх үүргийг хангахаар уг эд хөрөнгийн хувьд үүссэн, эсвэл уг эд хөрөнгийг худалдан авахад санхүүжүүлэхээр бий болсон өрийн үүргийг хангахаар үүссэн Барьцааны Эрхүүд; эсвэл
  - (ii) Банкны ердийн гүйлгээнд анх үүсч, ийнхүү үүссэнээс хойш нэгээс илүүгүй жилийн хугацаанд эргэн төлөгдөх өрийн үүргийг хангахаар үүссэн Барьцааны Эрхүүд.

## 5.02 дахь Хэсэгт. Мэдээ Тайлан

- (a) Банкнаас үндэслэл бүхий хүсэлт ирүүлсэн тохиолдолд ЕСБХБ-ны Гишүүн нь Банкинд дараах мэдээллийг Банкинд гаргаж өгнө:






- (i) Тухайн Гишүүний нутаг дэвсгэр дэх санхүү, эдийн засгийн байдлын тухай мэдээлэл – үүнд, тухайлбал, ЕСБХБ-ны Гишүүний төлбөрийн баланс, Гадаад Өр, түүнчлэн ЕСБХБ-ны Гишүүний өмчийн эрх, удирдлага дор оршдог, эсвэл түүний өмнөөс буюу түүний эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг аливаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, эсвэл төв банк, валютын тогтворжуулалтын нөөц санг, эсвэл үүнтэй төстэй этгээдийн Гадаад Өрийг хамруулна;
- (ii) Зах зээлийн эдийн засагт шилжихэд чиглэсэн эдийн засгийн реформ, арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл – үүнд, тухайлбал, Төсөлд нөлөөлж болзошгүй, эдийн засгийн салбар тус бүр дэх бүтцийн өөрчлөлт, хувьчлал, тухайн салбарын эрх зүй, бодлого зохицуулалтын орчны өөрчлөлт шинэчлэлтийг хамруулна..
- (b) ЕСБХБ-ны Гишүүн нь Банкны төлөөлөгчдийг Зээл, эсвэл Төслийн зорилгоор өөрийнх нь нутаг дэвсгэрт айлчлах боломжоор хангана.
- (c) Зээлдэгч ба Төслийн Байгууллага бүр Зээлийг бүхэлд нь эргэн төлж дуусах хүртэл, эсвэл цуцлах хүртэл Зээлийн хэлэлцээрт заасны дагуу дараах тайланг Банкинд ирүүлэх буюу зохих бусад этгээдээс ийнхүү ирүүлэх явдлыг хангана:
  - (i) Зээлийн хэлэлцээрт заасан санхүүгийн үүргийн биелэлтийн талаарх тогтмол санхүүгийн тайлан, мэдээ;
  - (ii) Банкны шаардлагад нийцсэн хэлбэр бүхий, Төслийн объектуудын ашиглалт, засвар үйлчилгээний талаарх тайлан мэдээ;
  - (iii) Зээлдэгчийн үйл ажиллагаатай холбоотой, байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх жилийн тайлан.

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ – ТАТВАР; ТӨЛБӨРТ ХЯЗГААРЛАЛТ ҮЛ ТОГТООХ

### 6.01 дахь Хэсэг. Татвар

- (a) ЕСБХБ-ны Гишүүн нь Татварын талаар дараах үүргийг хүлээнэ:
  - (i) Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийн төлбөрийг Гишүүнээс ногдуулдаг, эсвэл түүний нутаг дэвсгэр дээр мөрддөг аливаа Татвар, суутгалаас чөлөөлнө;
  - (ii) Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, аливаа Төслийн Гэрээ, түүнчлэн энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх бусад баримт бичгийг байгуулах, нөгөө талд хүргэх, бүртгүүлэхэд ногдох, ЕСБХБ-ны Гишүүнээс ногдуулдаг, эсвэл түүний нутаг дэвсгэр дээр мөрддөг аливаа Татвараас чөлөөлнө.
- (b) Зээлийг ЕСБХБ-ны Гишүүнээс ногдуулдаг, эсвэл түүний нутаг дэвсгэр дээр мөрддөг аливаа Татварыг төлөхөд ашиглахыг хориглоно.



- (с) Дээрх (b) заалтад заасан шаардлагыг хангах үүднээс Банк Зээлдэгчид мэдэгдэх замаар аль нэг Зардлын Ангилалд хамаарах зардлуудын эзлэх хувийг нэмэгдүүлэх, эсвэл бууруулж болно.

## 6.02 дахь Хэсэг. Төлбөрийг Үл Хязгаарлах

Зээлийн үндсэн дүн, хүү, Шимтгэлүүдийг төлөхөд ЕСБХБ-ны Гишүүнээс ногдуулдаг, эсвэл түүний нутаг дэвсгэр дээр мөрддөг аливаа төрлийн хязгаарлалт тогтоохгүй байх явдлыг Гишүүн хангах үүрэгтэй.

## ДОЛООДУГААР ЗҮЙЛ – ЗЭЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ; ТҮРГЭСГЭЖ ТӨЛӨХ

### 7.01 дэх Хэсэг. Түдгэлзүүлэх

- (a) Дараах тохиолдолд Банк Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэж, Зээлдэгчийн Зээл Татан Авалтын эрхийг бүхэлд, эсвэл хэсэгчлэн түдгэлзүүлж (түр зогсоож) болно:

- (i) Зээлдэгч дор дурдсан гэрээнд төлөхөөр заасан Зээлийн үндсэн дүн, хүү, Банкинд төлөх ёстой бусад аливаа төлбөрийг төлөөгүй (Батлан Даагч, эсвэл аливаа гуравдагч этгээд уг төлбөрийг гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран):

(A) Зээлийн хэлэлцээр;

(B) Банк, Зээлдэгчийн хооронд байгуулсан зээлийн, батлан даалтын бусад гэрээ; эсвэл

(C) Зээлдэгчийн зөвшөөрснөөр аливаа гуравдагч этгээдийн өмнө Банкны хүлээсэн батлан даалт, санхүүгийн бусад үүргийн улмаас бий болсон Зээлдэгчийн аливаа нөхөн төлбөр, үүнтэй төстэй үүргийг тусгасан бусад гэрээ хэлцэл;


- (ii) Батлан Даагч дор дурдсан гэрээнд төлөхөөр заасан Зээлийн үндсэн дүн, хүү, Банкинд төлөх ёстой бусад аливаа төлбөрийг төлөөгүй:

(A) Батлан Даалтын Гэрээ;

(B) Банктай байгуулсан зээлийн, батлан даалтын бусад гэрээ; эсвэл

(C) Батлан Даагчийн зөвшөөрснөөр аливаа гуравдагч этгээдийн өмнө Банкны хүлээсэн батлан даалт, санхүүгийн бусад үүргийн улмаас бий болсон Батлан Даагчийн аливаа нөхөн төлбөр, үүнтэй төстэй үүргийг тусгасан бусад гэрээ хэлцэл;;

- (iii) Зээлдэгч, эсвэл Батлан Даагч (засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж) нь Зээлдэгч, Батлан Даагч, эдгээрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэг нэгжийн Банктай




байгуулсан гэрээнд, эсвэл ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулсан Гэрээний 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан аливаа бусад үүргээ Банкны өмнө биелүүлээгүй;

- (iv) аливаа Төсөл Хэрэгжүүлэгч нь Төслийн Гэрээнд заасан аливаа үүргээ биелүүлээгүй;
- (v) Зээлдэгч, Батлан Даагч нь Банктай байгуулсан аливаа бусад зээлийн, эсвэл батлан даалтын гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас Банк Зээлдэгч, эсвэл Батлан Даагчийн тухайн зээлийн хэлэлцээрийн дагуу Зээл Татан Авалт хүссэн өргөдөл гаргах эрхийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн түдгэлзүүлсэн;
- (vi) Зээлийн хэлэлцээрийг байгуулснаас хойш Төслийг хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгч нь Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл Төслийн Гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй байдалд хүргэх үйл явдал бий болж, онцгой нөхцөл байдал үүссэн;
- (vii) НҮБ-ын Аюулгүй Байдлын Зөвлөлөөс НҮБ-ын Дүрмийн 7 дугаар Бүлэгт заасны дагуу гаргасан шийдвэрийн дагуу Зээл Татан Авалтыг хориглосон;
- (viii) ЕСБХБ-ны Гишүүний Банкин дахь гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн, эсвэл Банкны гишүүнээс гарсан, эсвэл Банкны гишүүнээс гарах мэдэгдлээ Банкинд хүргүүлсэн;
- (ix) Зээлийн хэлэлцээрийг байгуулах үеийн Зээлдэгч (ЕСБХБ-ны Гишүүн биш тохиолдолд), эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч (эсвэл Төслийн аливаа хэсгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий аливаа бусад байгууллага)-ын үүсгэн байгуулсан эрх зүйн хэлбэрт өөрчлөлт орсон;
- (x) Төсөлд зориулж (Банкнаас өөр) зээлдүүлэгчээс ("Хамтарсан Зээлдүүлэгч") Зээлийн хэлэлцээрт олгохоор заасан санхүүжилт ("Хамтын Зээл")-ын хувьд дараах үйл явдал бий болсон:


(A) Хамтын Зээлийг олгохоор Хамтарсан Зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээ (the "Хамтын Зээлийн хэлэлцээр") хүчин төгөлдөр болох өдрийг Зээлийн хэлэлцээрт тусгасан боловч уг Хамтын Зээлийн хэлэлцээр уг өдөр (эсвэл Банкны бичгээр заасан бол үүнээс хойших өөр өдөр)-өөс ("Хамтын Зээлийн Эцсийн Өдөр") өмнө багтан хүчин төгөлдөр болоогүй; гэхдээ хэрэв Зээлийн хэлэлцээр, тухайн Төслийн Гэрээ, Батлан Даалтын Гэрээнд заасан, Зээлдэгч (эсвэл тухайн Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл Батлан Даагч)-ийн хүлээсэн үүрэгтэй адил нөхцөл бүхий эх үүсвэрийг өөр эх сурвалжаас татах боломжтой болохыг Зээлдэгч (эсвэл тухайн Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл Батлан Даагч) Банкинд хангалттай нотолж чадвал энэ заалт үл үйлчилнэ;

(B) Доорх (C) заалтад зааснаас бусад тохиолдолд, (X) Хамтын Зээлийн хөрөнгөөс авч ашиглах эрх Хамтын Зээлийн хэлэлцээрт заасан нөхцөл, журмын дагуу бүхэлдээ, эсвэл хэсэгчлэн түдгэлзсэн, цуцлагдсан, дуусгавар болсон; эсвэл (Y)



Хамтын Зээлийг эргэн төлөхөөр гэрээнд заасан хугацаанаас өмнө эргүүлэн төлөх үүрэг үүссэн; эсвэл

- (C) Дээрх (B) заалт дараах тохиолдолд - (X) ийнхүү түдгэлзсэн, цуцлагдсан, дуусгавар болсон, эсвэл хугацаанаас нь өмнө төлүүлсэн нь уг Хамтын Зээлийн хүлээн авагчийн Хамтын Зээлийн хэлэлцээрт заасан аливаа үүргээ үл биелүүлснээс эс шалтгаалсан, ба (Y) Зээлийн хэлэлцээр, тухайн Төслийн Гэрээ, Батлан Даалтын Гэрээнд заасан, Зээлдэгч (эсвэл тухайн Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл Батлан Даагч)-ийн хүлээсэн үүрэгтэй адил нөхцөл бүхий эх үүсвэрийг өөр эх сурвалжаас татах боломжтой болохыг Зээлдэгч (эсвэл тухайн Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл Батлан Даагч) Банкинд хангалттай нотолж чадсан бол үйлчилнэ.
- (xi) Зээлдэгч (Банкны гишүүн биш тохиолдолд) Зээлийн хэлэлцээрийг байгуулах үеийн байдлаар Зээлдэгчээс Банкинд мэдээлсэн, Зээлдэгчийн нөхцөл байдалд зарчмын сөрөг нөлөө бүхий өөрчлөлт гарсан;
- (xii) Зээлийн хэлэлцээр, тухайн Төслийн Гэрээ, Батлан Даалтын Гэрээний хүрээнд Зээлдэгч (эсвэл тухайн Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл Батлан Даагч)-аас гаргасан мэдэгдэл нь зарчмын хувьд ташаа, эсвэл үнэн байдалд үл нийцсэн;
- (xiii) Зээлдэгчийн (ЕСБХБ-ны Гишүүн биш), эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн (Төслийн аливаа бүрэлдэхүүн хэсгийг хариуцан хэрэгжүүлэх өөр бусад этгээдийн) эрх зүйн байдал, өмчлөл, хяналтад өөрчлөлт орж, Зээлийн хэлэлцээр, эсвэл Төслийн гэрээ байгуулах үеийнхээс өөр болсон нь Зээлдэгч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгчийн (эсвэл өөр бусад этгээдийн) Зээлийн хэлэлцээр, Төслийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх, эсвэл Төслийн зорилгод хүрэх чадварт нь сөргөөр нөлөөлнө гэж Банк үзсэн;
- (xiv) 7.06(c), 7.06(d), 7.06(e) заалтуудад заасан үйл явдал тохиолдсон;
- (xv) ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулсан Гэрээний 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Банкны Захирлуудын Зөвлөлөөс шийдвэрлэсний дагуу ЕСБХБ-ны Гишүүний Банкны нөөцөөс авч ашиглах эрхийг түдгэлзүүлсэн, бусад байдлаар уг эрхийг хязгаарласан;
- (xvi) Зээлдэгч (ЕСБХБ-ны Гишүүн биш), Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл эдгээрийн Хамаарал бүхий этгээдийг Банкнаас санхүүжилт авах эрхгүй хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтад (ийм жагсаалтыг Банкны вэб сайтад байршуулна) оруулсныг Банк Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журмын хүрээнд тогтоосон;
- (xvii) Зээлийн хэлэлцээрт заасан бусад үндэслэл.
- (b) Зээлийн хөрөнгөөс авч хэрэглэх Зээлдэгчийн эрхийг сэргээсэн тухай Банк Зээлдэгчид мэдэгдээгүй бол Зээлдэгчийн Зээл Татан Авалтын эрхийг бүхэлд, эсвэл хэсэгчлэн түдгэлзүүлсэн нь ийнхүү түдгэлзүүлэх үндэслэл болсон үйл явдал (эсвэл үйл явдлууд) арилах хүртэл үргэлжилнэ; гэхдээ Зээлдэгчийн Зээл Татан Авалтын эрхийг сэргээсэн




Банкны мэдэгдэл ирсэн бол уг мэдэгдэлд заасан хязгаар, нөхцөлийн хүрээнд л сэргээх ба уг мэдэгдэл нь энэ Хэсэгт заасан үйл явдлын хувьд Банкны эдлэх аливаа эрх, бүрэн эрх, шүүхийн журмаар шаардах эрхэд үл нөлөөлөх буюу эдгээрийн үйлчлэлийг үл хязгаарлана.

## 7.02 дахь Хэсэг. Банкны Санаачилгаар Зээлийг Цуцлах

- (a) Банк нь Зээлдэгч, Батлан Даагчтай санал солилцож, Зээлийн тодорхой хэсэг Төслийн зардлыг санхүүжүүлэхэд шаардлагагүй болсон гэж дүгнэвэл Зээлдэгч, Батлан Даагчид энэ тухай мэдэгдэж, Зээлийн тухайн хэсгийг цуцалж болно. Зээл Олгох Сүүлчийн Өдрийн байдлаар үлдсэн Боломжит Үлдэгдлийг цуцалсанд тооцно.
- (b) Зээлдэгчийн Зээл Татан Авалтын эрхийг түдгэлзүүлснээс хойш тасралтгүй гуч (30) хоног өнгөрсөн тохиолдолд Банк нь Зээлдэгч, Батлан Даагчид энэ тухай мэдэгдэж, Зээлийн тухайн хэсгийг цуцалж болно.
- (c) Банк дараах тохиолдолд Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдсэний үндсэн дээр дор дурдсан зарцуулалттай тэнцүү хэмжээний Зээлийн дүнг цуцалж болно:
  - (i) Аливаа худалдан авалт нь Зээлийн хэлэлцээрт заасан (эсвэл иш татсан) худалдан авалтын нөхцөл, журамд үл нийцсэн болохыг Банк тогтоосон ба Зээлээр санхүүжүүлэх шалгуурт нийцэхээр байсан бол тухайн худалдан авалтын зарцуулалтыг тодорхойлсон;
  - (ii) Зээлийн хөрөнгийг Зээлийн хэлэлцээрт зааснаас өөр зориулалтаар зарцуулсныг Банк тогтоосон ба ийнхүү зарцуулсан дүнг тодорхойлсон;
  - (iii) Зээлийн хөрөнгөөр бүхэлдээ, эсвэл хэсэгчлэн санхүүжүүлэх аливаа гэрээний хувьд уг гэрээний хүрээнд худалдан авалт хийх, гэрээг байгуулах явцад Зээлдэгч, Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл эдгээрийн Хамаарал бүхий Этгээд нь Хориглосон Үйл Ажиллагааг эрхэлсэн ба Зээлдэгч, Батлан Даагч нь үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн, Банкны шаардлагад нийцсэн, зохих шуурхай арга хэмжээг аваагүй болохыг Банк тогтоосон ба Зээлээр санхүүжүүлэх шалгуурт нийцэхээр байсан бол тухайн гэрээний зарцуулалтыг тодорхойлсон.

Банкнаас Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэл өгсөн өдрөөс эхлэн цуцалтыг хүчинтэйд тооцно.

- (d) Зээлдэгч (ЕСБХБ-ны Гишүүн биш), Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл эдгээрийн Хамаарал бүхий этгээдийг Банкнаас санхүүжилт авах эрхгүй хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтад (ийм жагсаалтыг Банкны вэб сайтад байршуулна) оруулсныг Банк Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журмын хүрээнд тогтоосон бол Банк Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэх замаар Зээлийг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн цуцалж болно. Банкнаас Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэл өгсөн өдрөөс эхлэн цуцалтыг хүчинтэйд тооцно.





- (е) Батлан Даагч нь Зээлдэгчийн татан аваагүй, үлдэгдэл Зээлийн хувьд 7.05 дахь хэсэгт заасны дагуу цуцлах тухай мэдэгдлийг Банкинд ирүүлсэн бол Банк ийнхүү татан аваагүй, үлдэгдэл Зээлийн дүнг цуцалсан гэж үзнэ.

#### **7.03 дахь Хэсэг. Зээлийг Түдгэлзүүлсэн, Цуцалсан нь Нөхцөлт Бус Нөхөн Төлөх Үүргийг Үл Хөндөх**

Нөхөн Төлбөрийн Үүргийн нөхцөлд тусгайлан өөрөөр заагаагүй бол Зээлийг түдгэлзүүлсэн, эсвэл цуцалсан нь 3.02(с) дахь Хэсэгт заасны дагуу Банкны нөхцөлт бус Нөхөн Төлбөрийн Үүрэгт ногдох мөнгөн дүнд үл хамаарна.

#### **7.04 дэх Хэсэг. Зээлдэгч, Батлан Даагчийн Үүрэг**

Зээлийг түдгэлзүүлсэн, эсвэл цуцалсныг үр харгалзан энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлагад өөрөөр заагаагүй бол Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээний бүхий л заалтууд хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.


#### **7.05 дахь Хэсэг. Батлан Даалтын Үүрэг Дуусгавар Болох**

Хэрэв Зээлдэгч Зээлийн үндсэн дүн, хүү, Зээлийн хэлэлцээрт заасан аливаа бусад төлбөрийг (Батлан Даагчийн үйлдэл, эс үйлдлээс шалтгаалснаас бусад тохиолдолд) хийгээгүй ба Батлан Даагч эдгээр төлбөрийг хийсэн тохиолдолд Батлан Даагч нь Банктай санал солилцсоны дараа, Банк ба Зээлдэгчид мэдэгдэх замаар, тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрийн байдлаар Зээлдэгчийн авч хэрэглээгүй ба 3.02(b) дахь Хэсэгт заасан Банкны нөхцөлт бус Нөхөн Төлөх Үүрэгт үл хамаарах Зээлийн аливаа үлдэгдэл дүнгийн хувьд Батлан Даалтын Гэрээгээр хүлээсэн үүргээсээ татгалзаж болно. Банкинд мэдэгдлийг хүргүүлснээр тухайн үлдэгдэл дүнгийн хувьд хүлээх Батлан Даагчийн үүрэг дуусгавар болно.

#### **7.06 дахь Хэсэг. Зээлийг Түргэсгэж Төлүүлэх**

Дараах үйл явдал дор дурдсан хугацаанд үргэлжилсэн тохиолдолд Банк ийнхүү үргэлжлэх үеэр хэдийд ч Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэж, Зээлийг цуцалж, ийнхүү цуцлах үеийн байдлаар эргэн төлөгдөөгүй Зээлийн үндсэн дүнг (зохих хүү, Шимтгэлүүдийн хамт) нэн даруй эргэн төлөхийг шаардах эрхтэй ба ийнхүү шаардсанаар Зээлийн үндсэн дүнг (зохих хүү, Шимтгэлүүдийн хамт) нэн даруй эргэн төлөх үүрэг үүснэ:

- (a) 7.01(a)(i), эсвэл 7.01(a)(ii) заалтад заасан үйл явдал бий болж, үүнээс хойш арван тав (15) хоног өнгөрсөн.
- (b) 7.01(a)(iii), эсвэл 7.01(a)(iv) заалтад заасан үйл явдал бий болж, Банкнаас Зээлдэгч, Батлан Даагчид зохих мэдэгдлийг ирүүлснээс хойш гуч (30) хоног өнгөрсөн.



- (с) Зээлдэгч, эсвэл Батлан Даагчийн Гадаад Өрийг тухайн гэрээнд заасан өдрөөс өмнө төлөхийг шаардсан.
- (d) Зээлдэгч (Банкны Гишүүн биш тохиолдолд), эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч өөр өөрсдийн өрийг хугацаанд төлж чадахгүй болсон, эсвэл Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн Хөрөнгийг нэхэмжлэгчдэд хуваарилах, эсвэл хуваарилж болзошгүй байдалд хүргэж болохуйц шаардлага, нэхэмжлэлийг Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч, эсвэл өөр бусад этгээд) гаргасан.
- (e) Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн Хяналт, эсвэл эрх зүйн харьяалал дор нь байдаг аливаа эрх бүхий төрийн байгууллага Зээлдэгч (Банкны Гишүүн биш тохиолдолд) (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийг татан буулгах, хаах, эсвэл түүний үйл ажиллагааг түр зогсоход чиглэсэн аливаа үйлдэл, арга хэмжээг авсан.
- (f) Зээлийн хэлэлцээрт заасан бусад үйл явдал бий болж, мөн Зээлийн хэлэлцээрт заасан бол тухайн хугацаагаар үргэлжилсэн бол.

## **НАЙМДУГААР ЗҮЙЛ – ШҮҮХИЙН ЖУРМААР АЛБАДАН БИЕЛҮҮЛЭХ; МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**


### **8.01 дэх Хэсэг. Шүүхийн Журмаар Албадан Биелүүлэх**

(a) Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ ба аливаа Төслийн Гэрээний талуудын эрх, үүрэг нь аливаа нэг улсын дотоодын хууль тогтоомжид өөрөөр зааснаас үл хамааран тухайн гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байж, шаардлагатай бол шүүхийн журмаар албадан биелүүлнэ. Эдгээр гэрээнүүдийн аливаа тал ямар ч нөхцөл байдалд ямар ч үндэслэлээр тухайн гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, эсвэл шүүхийн журмаар албадан биелүүлэх боломжгүй гэх нэхэмжлэл, тайлбар гаргах эрхгүй.

(b) Стандарт Нөхцөл, Шаардлага, Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, аливаа Төслийн Гэрээний аливаа бусад зүйл, заалтыг үр харгалзан, аливаа этгээд Төсөлтэй холбогдуулан Хориглосон үйл ажиллагаа явуулсан (Зээлийн хөрөнгийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд ашиглах замаар санхүүжүүлэх аливаа хэлцлийг оруулах бөгөөд үүгээр үл хязгаарлана) гэх үндэслэл байх тохиолдолд Банк Албадан Хэрэгжүүлэх Бодлого, Журмыг удирдлага болгон, түүнд заасан Албадан Хэрэгжүүлэх, Нийтэд Мэдээлэх болон бусад арга хэмжээг авах эрхтэй болохыг Зээлдэгч, Батлан Даагч, мөн Төсөл Хэрэгжүүлэгч бүр хүлээн зөвшөөрч байна.

### **8.02 дахь Хэсэг. Батлан Даагчийн Үүрэг**

Батлан Даагчийн Батлан Даалтын Гэрээнд заасан үүргийг гагцхүү гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу батлан даалтын үүргийг гүйцэтгэснээр биелүүлсэн гэж үзнэ. Батлан Даалтын Гэрээнд заасан үүргийг биелүүлэхийн тулд Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ид хандаж аливаа мэдэгдэл, шаардлага урьдчилж хүргүүлэх, эсвэл түүний




эсрэг өөр аливаа үйлдэл, арга хэмжээ авах, эсвэл Батлан Даагчид хандаж Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн аливаа дефолтын талаар мэдэгдэл, шаардлага урьдчилж хүргүүлэх шаардлагагүй. Дараах үйл явдлын аль нь ч Батлан Даалтын Гэрээний үүргийн биелэлтийг үл хязгаарлана: Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн үүргээ биелүүлэх хугацааг сунгасан, Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн эсрэг авах арга хэмжээг түр зогсоосон, Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ид буулт хийсэн, хөнгөлөлт олгосон; Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн эсрэг, эсвэл Зээлийн барьцааны хувьд аливаа эрх, бүрэн эрх, шүүхийн журмаар шаардах эрхийг хэрэгжүүлсэн, эсвэл хэрэгжүүлээгүй, эсвэл ийнхүү хэрэгжүүлэхийг хойшлуулсан; Зээлийн хэлэлцээр (эсвэл аливаа Төслийн Гэрээ)-нд заасан бол уг гэрээний зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан; Зээлдэгч (эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч) нь хууль тогтоомжийн шаардлага, Батлан Даагч (эсвэл Батлан Даагчийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж)-ийн даалгаврыг биелүүлээгүй.

### 8.03 дахь Хэсэг. Эрхээ Эс Эдлэх


Аливаа дефолт бий болсны дараа Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээний аль нэг тал нь тухайн гэрээгээр эдлэх эрх, бүрэн эрх, шүүхийн журмаар шаардах эрхээ хэрэгжүүлээгүй, эсвэл хэрэгжүүлэхээ хойшлуулсан нь түүний уг эрх, бүрэн эрх, шүүхийн журмаар шаардах эрхийн байдлыг үл хөндөх ба эдгээр эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан, эсвэл тухайн дефолтыг зөвшөөрсөн гэж үзэхгүй. Түүнчлэн гэрээний дээрх тал аль нэг дефолтын хувьд хариу арга хэмжээ авсан, эсвэл аль нэг дефолтыг зөвшөөрсөн нь өөр, эсвэл дараа дараагийн дефолтын хувьд уг талын эдлэх эрх, бүрэн эрх, шүүхийн журмаар шаардах эрхийг хөндөхгүй буюу хязгаарлахгүй.

### 8.04 дэх Хэсэг. Маргаан Шийдвэрлэх

- (a) Зээлийн хэлэлцээр болон Батлан Даалтын Гэрээ, түүнчлэн Төслийн Гэрээ бүрийн талууд нь нэг талаас Банк, нөгөө талаас нэг буюу хэд хэдэн талын хооронд эдгээр гэрээг зөрчсөн, дуусгавар болгосон, хүчин төгөлдөр бус болсон, эсвэл эдгээр гэрээтэй бусад байдлаар холбоотой үүссэн аливаа маргааныг эвээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү эвээр шийдвэрлэхийн тулд аль нэг тал санаачилга гаргасан бол нөгөө тал нь уг санаачлагч талтай нэн даруй уулзаж, үүссэн маргааныг хэлэлцэх ба санаачлагч талаас бичгээр хүсэлт ирүүлсэн бол маргааны талаар санаачлагч талын бичгээр ирүүлсэн байр суурийн талаар өөрийн хариуг мөн бичгээр өгнө.
- (b) Талууд хоорондын маргаан, түүнтэй холбоотой аливаа шаардлагыг дээрх (a) заалтад заасан уулзах санаачилгыг гаргаснаас хойш жар (60) хоногийн дотор мөн (a) заалтын дагуу эвээр шийдвэрлэж чадаагүй бол тухайн маргаан, түүнтэй холбоотой аливаа шаардлагыг энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлага хүчин төгөлдөр болох үед мөрдөж буй Олон Улсын Худалдааны Хуулийн НҮБ-ын Комиссын Арбитрын Дүрэм (UNCITRAL Arbitration Rules)-ийн дагуу, дараах нөхцөл бүхий арбитрын журмаар шийдвэрлүүлнэ:
- (i) Арбитр бүрэлдэхүүн гурван (3) арбитрчаас бүрдэнэ.



- (ii) Олон Улсын Худалдааны Хуулийн НҮБ-ын Комиссын Арбитрын Дүрмийн зорилтын хувьд арбитраждыг томилох эрх бүхий этгээд нь Арбитрын Байнгын Шүүхийн Ерөнхий Нарийн Бичгийн Дарга байна.
- (iii) Арбитрын Байнгын Шүүхийн Ерөнхий Нарийн Бичгийн Дарга арбитраждыг томилох тохиолдолд тэрбээр арбитражийн шаардлагыг хангах аливаа этгээдийг Олон Улсын Худалдааны Хуулийн НҮБ-ын Комиссын Арбитрын Дүрмийн 9.2, эсвэл/болон 9.3 дугаар зүйлд заасны дагуу томилох эрхтэй.
- (iv) Арбитрын маргаан шийдвэрлэх газар: Нидерланд Улсын Гааг хот.
- (v) Арбитрын ажиллагааг англи хэл дээр явуулна.
- (vi) Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ нь олон улсын нийтийн эрх зүй ба түүний эх сурвалж нь:
- (A) ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулсан Гэрээ ба харилцан адил байх зарчмыг баримталсан аливаа бусад гэрээ хэлэлцээр;
- (B) кодификаци (эрх зүйн акт)-ийн хэлбэр бүхий ёс заншлын хэм хэмжээ, эсвэл нийтээр мөрдөж төлөвшсөн ёс заншлын хэм хэмжээ гэж нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, улс гүрэн, олон улсын санхүүгийн байгууллагад үйлчлэх олон улсын гэрээ хэлэлцээрийн заалтууд (талууд шууд дагаж мөрдөх ёстой эсэхээс үл хамааран);
- (C) олон улсын ёс заншлын бусад хэлбэрүүд, үүнд, тухайлбал, эрх зүйн хувьд шинээр үүрэг бий болгохуйц нийтлэг, тогтмол, үргэлжилсэн шинж байдлыг агуулсан, улс гүрэн, олон улсын санхүүгийн байгууллагуудын зан заншил;
- (D) холбогдох эрх зүйн ерөнхий зарчмууд .
- (vii) Олон Улсын Худалдааны Хуулийн НҮБ-ын Комиссын Арбитрын Дүрмийн аливаа заалтыг үл харгалзан арбитраж бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах аливаа арга хэмжээг Банкны эсрэг авах бүрэн эрхгүй ба Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээний нөгөө тал арбитраж шийдвэр гарахаас өмнө уг шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг Банкны эсрэг авахаар аливаа шүүхэд хандах эрхгүй.
- (viii) Арбитраж бүрэлдэхүүн нь Банк, Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгчээс гаргасан нэхэмжлэлийн дагуу, Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, аливаа Төслийн Гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг арбитраж ажиллагаанд хүлээн авч, хянан хэлэлцэх, улмаар арбитраж шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Үүнээс бусад тохиолдолд өөр талууд, эсвэл өөр маргааныг арбитраж ажиллагаанд хүлээн авах, хянан хэлэлцэхгүй ба өөр арбитраж ажиллагаатай нэгтгэхгүй.





- (с) Энэ Хэсэгт заасныг үл харгалзан, энэхүү Стандарт Нөхцөл, Шаардлага, Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээний аливаа зүйл заалтыг ЕСБХБ-ийг Үүсгэн Байгуулсан Гэрээ, олон улсын гэрээ хэлэлцээр, бусад хамаарах эрх зүйн хэм хэмжээний дагуу Банкны эдлэх халдашгүй дархан эрх ямба, онцгой эрх, хөнгөлөлт чөлөөлөлтөөс татгалзсан, үйлчлэлийг нь цуцалсан, эсвэл өөрчилсөн явдал биш ба ийнхүү татгалзсан, цуцалсан, өөрчилсөн гэж үзэхгүй.
- (d) Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээгээр Банкинд төлөх ёстой аливаа мөнгөн дүнг тухайн гэрээтэй холбоотой үүссэн арбитрын ажиллагааны үеэр Банкнаас ирүүлсэн сертификатад тусгах ба уг сертификат нь төлөх ёстой мөнгөн дүнгийн prima facie нотлох баримт мөн.

## ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ – ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ДУУСТАВАР БОЛОХ


### 9.01 дэх Хэсэг. Гэрээ Хүчин Төгөлдөр Болох Өдөр

Банк, Зээлдэгч хоёр өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ болон аливаа Төслийн Гэрээ нь 9.02, 9.03 дахь Хэсгүүдэд заасан нотлох баримтуудыг Банк хүлээн авч, зөвшөөрсөн тухай мэдэгдлийг Банкнаас Зээлдэгч ба Батлан Даагчид илгээсэн өдөр хүчин төгөлдөр болно.

### 9.02 дахь Хэсэг. Гэрээ Хүчин Төгөлдөр Болох Урьдач Нөхцөлүүд

7.01(a), эсвэл 7.06 дахь Хэсгүүдэд заасан үйл явдал бий болоогүй гэж Банк тодорхойлохоос нааш, түүнчлэн дараахыг нотолсон, Банкны шаардлагад нийцсэн агуулга, хэлбэр бүхий баримтыг Банкинд ирүүлэх хүртэл Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ болон аливаа Төслийн Гэрээ хүчин төгөлдөр болохгүй:

- (a) Зээлийн хэлэлцээр болон Батлан Даалтын Гэрээг Зээлдэгч ба Батлан Даагчийг төлөөлж байгуулах, нөгөө талд хүргүүлэх эрхийг төрийн эрх бүхий байгууллагын ба компанийн зохих шийдвэрээр олгосон, эсвэл ийнхүү байгуулсан буюу хүргүүлснийг зөвшөөрч баталсан.
- (b) Төслийн Гэрээг (хэрэв байгуулсан бол) Төсөл Хэрэгжүүлэгч тус бүрийг төлөөлж байгуулах, нөгөө талд хүргүүлэх эрхийг төрийн эрх бүхий байгууллагын ба компанийн бүхий л зохих шийдвэрээр олгосон, эсвэл ийнхүү байгуулсан буюу хүргүүлснийг зөвшөөрч баталсан.
- (с) Зээлийн хэлэлцээрт урьдач нөхцөл гэж тусгасан, аливаа бусад үйл явдал.





### 9.03 дахь Хэсэг. Хууль Зүйн Дүгнэлт

9.02 дахь Хэсэгт заасан нотлох баримтын хүрээнд, Зээлдэгч, Батлан Даагч, эсвэл аливаа Төсөл Хэрэгжүүлэгч нь Зээлийн хэлэлцээрт заасан, эсвэл үндэслэл бүхий Банкны хүсэлтэд заасан аливаа асуудлаар, Банкны зөвшөөрсөн хуулийн зөвлөхөөс хууль зүйн дүгнэлт (эсвэл дүгнэлтүүд)-ийг гаргуулж (Банкны шаардлагад нийсэн агуулга, хэлбэр бүхий) Банкинд ирүүлэх буюу бусад этгээдийг ийнхүү гаргуулж Банкинд ирүүлэх явдлыг хангана. Тухайлбал, хууль зүйн дүгнэлтэд дараах асуудлыг тусгана:


- (a) Зээлдэгчийн хувьд эрх бүхий этгээд Зээлдэгчийг төлөөлж, Зээлдэгчийн өмнөөс Зээлийг Гэрээг байгуулсан ба нөгөө талд хүргүүлсэн, түүнчлэн Зээлийн хэлэлцээр нь хүчин төгөлдөр, заавал биелэх, түүнд заасны дагуу шүүхийн журмаар албадан биелүүлэх Зээлдэгчийн үүрэг мөн болохыг.
- (b) Батлан Даагчийн хувьд эрх бүхий этгээд Батлан Даагчийг төлөөлж, Батлан Даагчийн өмнөөс Батлан Даалтын Гэрээг байгуулсан ба нөгөө талд хүргүүлсэн, түүнчлэн Батлан Даалтын Гэрээ нь хүчин төгөлдөр, заавал биелэх, түүнд заасны дагуу шүүхийн журмаар албадан биелүүлэх Батлан Даагчийн үүрэг мөн болохыг.
- (c) Төсөл Хэрэгжүүлэгч тус бүрийн хувьд эрх бүхий этгээд уг Төсөл Хэрэгжүүлэгчийг төлөөлж, уг Төсөл Хэрэгжүүлэгчийн өмнөөс тухайн Төслийн Гэрээг байгуулсан ба нөгөө талд хүргүүлсэн, түүнчлэн уг Төслийн Гэрээ нь хүчин төгөлдөр, заавал биелэх, түүнд заасны дагуу шүүхийн журмаар албадан биелүүлэх уг Төсөл Хэрэгжүүлэгчийн үүрэг мөн болохыг.

### 9.04 дэх Хэсэг. Хүчин Төгөлдөр Болоогүй Үндэслэлээр Гэрээг Дуусгавар Болгох

Хэрэв Зээлийн хэлэлцээр нь энэ Хэсэгт заасны дагуу Зээлийн хэлэлцээрт заасан өдөр хүчин төгөлдөр болоогүй бол Банк ийнхүү хугацаа хоцорсон шалтгааныг харгалзсаны үндсэн дээр уг өдрийг өөр өдрөөр сольсноос бусад тохиолдолд Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ болон аливаа Төслийн Гэрээнд заасан Зээлдэгчийн бүхий л үүрэг дуусгавар болно. Ийнхүү тогтоосон өөр өдрийг Банк нэн даруй Зээлдэгч, Батлан Даагчид мэдэгдэнэ.

### 9.05 дахь Хэсэг. Гэрээг Биелүүлснээр Дуусгавар Болгох

Зээлийн нийт үндсэн дүнг (хуримтлагдсан нийт хүү, Шимтгэлүүдийн хамт) хугацаанд нь төлж барагдуулсан тохиолдолд Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ болон аливаа Төслийн Гэрээ ба талуудын эдгээр гэрээгээр хүлээсэн бүхий л үүрэг дуусгавар болно.



## АРАВДУГААР ЗҮЙЛ – МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ; ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ; НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

### 10.01 дэх Хэсэг. Мэдэгдэл Хүргүүлэх


Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээ, эсвэл эдгээр гэрээнд заасан өөр бусад гэрээний дагуу ирүүлэх аливаа мэдэгдэл, эсвэл хүсэлтийг бичгээр үйлдэнэ. 9.01 дахь Хэсэгт өөрөөр заагаагүй бол уг мэдэгдэл, эсвэл хүсэлтийг түүнийг хүлээн авагч талд Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээнд заасан хаягаар нь, эсвэл хүлээн авагч тал мэдэгдэл, эсвэл хүсэлтийг ирүүлэх гэж буй талд бичгээр мэдэгдсэн өөр хаягаар гаргацтай байдлаар ирүүлнэ. ЕСБХБ-ны Зээлийн Журамд өөрөөр заагаагүй бол (Зээл Татан Авалтын өргөдөл, бусад холбогдох) мэдэгдэл, эсвэл хүсэлтийг гараас гарт, шуудангаар, эсвэл pdf буюу бусад форматаар электрон шуудангаар тус тус хүргүүлж болно.

### 10.02 дахь Хэсэг. Бүрэн Эрх

Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлдэгч (эсвэл Батлан Даалтын Гэрээний дагуу Батлан Даагч, эсвэл аль нэг Төслийн Гэрээний дагуу Төсөл Хэрэгжүүлэгч)-ын авах аливаа арга хэмжээ, үйлдэх аливаа баримт бичгийн хувьд Зээлдэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч (эсвэл Батлан Даагчийн Эрх Бүхий Төлөөлөгч, эсвэл уг Төсөл Хэрэгжүүлэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч) өөрөө, эсвэл уг Эрх Бүхий Төлөөлөгч Зээлдэгч (эсвэл Батлан Даагч, эсвэл уг Төсөл Хэрэгжүүлэгч)-ийн өөр албан тушаалтанд бичгээр эрх олгосон бол уг өөр албан тушаалтан уг арга хэмжээ авах, эсвэл уг баримт бичгийн үйлдэнэ. Зээлдэгч (эсвэл Батлан Даагч, эсвэл Төсөл Хэрэгжүүлэгч бүр) уг эрх бүхий албан тушаалтан бүрийн бүрэн эрх, гарын үсгийн загварыг нотлох хангалттай нотлох баримтыг Банкинд ирүүлнэ.

### 10.03 дахь Хэсэг. Нэмэлт Өөрчлөлт

- (a) Зээлийн хэлэлцээрт нэг талаас Зээлдэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч, нөгөө талаас Банкны эрх бүхий албан тушаалтан нар бичгээр үйлдэж, гарын үсэг зурах замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Хэрэв тухайн нэмэлт, өөрчлөлт нь Батлан Даагчийн үүргийг нэмэгдүүлж байна гэж Банк үзвэл Батлан Даагчийн Эрх Бүхий Төлөөлөгч уг нэмэлт, өөрчлөлтөд мөн гарын үсэг зурна.
- (b) Батлан Даалтын Гэрээнд нэг талаас Батлан Даагчийн Эрх Бүхий Төлөөлөгч, нөгөө талаас Банкны эрх бүхий албан тушаалтан нар бичгээр үйлдэж, гарын үсэг зурах замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- (c) Аливаа Төслийн Гэрээнд нэг талаас Төсөл Хэрэгжүүлэгчийн Эрх Бүхий Төлөөлөгч, нөгөө талаас Банкны эрх бүхий албан тушаалтан нар бичгээр үйлдэж, гарын үсэг зурах замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



#### 10.04 дэх Хэсэг. Англи Хэл


Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, эсвэл аливаа Төслийн Гэрээний дагуу нөгөө талд ирүүлэх баримт бичгийг англи хэл дээр үйлдэнэ. Өөр хэл дээр үйлдсэн баримт бичгийг албан ёсны гэж гэрчилсэн англи орчуулга дагалдах ба уг албан ёсны орчуулгыг эцсийнх гэж үзнэ.

#### 10.05 дахь Хэсэг. Гэрээг Үйлдэх Хувь

Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ болон аливаа Төслийн Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох ба энэ тохиолдолд хувь бүрийг эх хувь гэж үзнэ.

#### 10.06 дахь Хэсэг. Мэдээллийн Ил Тод Байдал

Банк нь Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, мөн Төслийн Гэрээ бүрийг, түүнчлэн эдгээр гэрээтэй холбоотой аливаа мэдээллийг (үүнд Зээлдэгч, Батлан Даагч, Төсөл Хэрэгжүүлэгч болон Төсөлтэй холбоотой аливаа баримт бичиг, мэдээллийг оруулах ба үүгээр үл хязгаарлана) өөрийн мэдээллийн хүртээмжийн бодлогын хүрээнд болон Зээлийн хэлэлцээр, Батлан Даалтын Гэрээ, мөн Төслийн Гэрээ бүрийн аль нэгтэй холбоотой маргааны улмаас Банкны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хангах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гуравдагч этгээдэд мэдээлж болно.



## ХАВСРАЛТ 1 – ЕВРОГООР ИЛЭРХИЙЛСЭН ЗЭЭЛ


### I хэсэг: Хүүгийн талаар Заалт

Хэрэв тухайн Зээлд Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн Валот нь евро бол 3.04(a) Хэсэгт заасан Холбогдох Зах зээлийн Хүүгийн Хувийг дараах байдлаар тодорхойлно:

- (i) Зээл Татан Авалт бүрийн эхний Хүү Тооцох Мөчлөгийн хувьд, тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах Хүү Тодорхойлох Өдрийн Брюселлийн цагаар өглөөний 11.00 цагийн байдлаар Референц Хуудсаар дамжуулан харуулсан, Еврогоор илэрхийлсэн хадгаламжид санал болгосон жилийн хувийг баримтална. Хэрэв тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах ийм хувь Референц Хуудаст харуулаагүй боловч тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаанаас богино ба урт хугацаа аль алинд хамаарах хувиуд Референц Хуудаст харуулсан тохиолдолд ("Референц Хувиуд") Референц Хуудаст нэг талаас тухайн Хүү Тооцох Мөчлөгийн хугацаанаас дараагийн богино хугацаанд, нөгөө талаас тухайн Хүү Тооцох Мөчлөгийн хугацаанаас дараагийн урт хугацаанд тус тус хамаарах Референц Хувиудад тулгуурлаж шулуун шугамын интерполяцийн аргаар тооцсон, тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаатай тэнцүү хугацаанд хамаарах хувийг (шаардлагатай бол их тоо руу бүхэлдэх ба аравтын дөрвөн оронгоос үл хэтрүүлэн) Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувьд тооцно; болон
- (ii) дараа дараагийн Хүү Тооцох Мөчлөгийн хувьд, тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаатай хамгийн их дүйцэж тэнцэх хугацаанд хамаарах Хүү Тодорхойлох Өдрийн Брюселлийн цагаар өглөөний 11.00 цагийн байдлаар Референц Хуудсаар дамжуулан харуулсан, Еврогоор илэрхийлсэн хадгаламжид санал болгосон жилийн хувийг баримтална (хэрэв хоёр тустаа хугацаа тухайн Хүү Тооцох Мөчлөгийн үргэлжлэх хугацаатай хоёулаа адил хэмжээгээр дүйцэж тэнцэх тохиолдолд тухайн хоёр хувийг дунжийг баримтална);

### Хэрэв

- (1) Референц Хуудсыг ашиглан Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийг аливаа шалтгааны улмаас тухайн үед тодорхойлох боломжгүй бол тухайн Хүү Тооцох Мөчлөгийн хугацаанд Хувьсагч Хүүгийн Хувиар эргэн төлөгдөх хуваарь бүхий Зээлтэй тэнцүү хэмжээтэй, Еврогоор илэрхийлсэн, тухайн Хүү Тооцох Мөчлөгтэй тэнцүү хугацаа бүхий хадгаламжийн хувьд Евро бүсийн банк хоорондын зах (Еврогийн хувьд)-ад идэвхтэй оролцдог, Банкны өөрийн сонгосон, 2-оос доошгүй том банкны зүгээс Евро бүсийн банк хоорондын зах дээрх тэргүүлэх банкнуудад санал болгосон жилийн хэд хэдэн хувиудын математик дунжийг Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувьд тооцно (шаардлагатай бол их тоо руу бүхэлдэх ба аравтын дөрвөн оронгоос үл хэтрүүлэн).



- (2) Хэрэв энэхүү 3.04(а) заалтын дагуу энэхүү Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийн математик дундаж нь тэгээс бага байхаар бол Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

## II Хэсэг: Тодорхойлолт


Хэрэв Зээлийн Валют нь евро бол өөрөөр зааснаас бусад тохиолдолд дараах нэр томьёо нь Стандарт Нөхцөл, Шаардлагад болон Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх Гэрээнд дор дурдсан утгыг илэрхийлнэ:

**“Хугацаа хэтэрсний Хүү Тодорхойлох Өдөр”** гэж тухайн Хугацаа хэтэрсний хүү тооцох Мөчлөгийн эхний өдрөөс Ажлын хоёр Өдрийн өмнөх өдрийг ойлгоно.

**“Хүү Тодорхойлох Өдөр”** гэж тухайн Хүү тооцох Мөчлөгийн эхний өдрөөс эсвэл Зээлийн хэлэлцээрт тодорхойлсон өдрөөс Ажлын хоёр Өдрийн өмнөх өдрийг ойлгоно.

**“Зах зээл Тогтворгүйжих Үйл явдал”** гэж (а) холбогдох Хүүг Тооцох Мөчлөгийн Хүү Тодорхойлох Өдөр эсвэл холбогдох Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн хувьд Хугацаа Хэтрүүлсний Хүү Тодорхойлох Өдрийн байдлаар (Зээлийн бүх, эсвэл түүний аль нэг хэсэгт Тогтмол Хүүгийн Хувийг мөрдөх хугацаанд тохиосон эсэхээс үл хамааран) Референц Хуудас байхгүйгээс ашиглах боломжгүй бөгөөд Евро бүсийн банк хоорондын зах зээл дээрх идэвхтэй томоохон банкуудаас зөвхөн нэг банк тухайн Хүүг Тооцох Мөчлөгийн Еврогийн хувьд мөрдөх Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувийг эсвэл холбогдох Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн тохиолдолд Еврогийн хувьд мөрдөх Хугацаа хэтрүүлсний Хүүгийн Хувийг Банкинд ирүүлсэн, эсвэл нэг ч банк ирүүлээгүй, эсвэл

(b) (дор дурдсан хүү тодорхойлох өдөр нь Зээлийн бүх, эсвэл түүний аль нэг хэсэгт Тогтмол Хүүгийн Хувийг мөрдөх хугацаанд тохиосон эсэхээс үл хамааран) Лондон хотод холбогдох Хүүг Тооцох Мөчлөгийн хувьд Хүү Тодорхойлох Өдөр (эсвэл холбогдох Хугацаа Хэтрүүлсний Хүүг Тооцох Мөчлөгийн хувьд Хугацаа Хэтрүүлсний Хүү Тодорхойлох Өдөр)-ийн ажлын цаг дуусахаас өмнө эсвэл Евро бүсийн банк хоорондын зах зээлээс тэнцүү хэмжээний хадгаламжийг татахад Банкнаас гарах зардал нь Холбогдох Зах Зээлийн Хүүгийн Хувиас хэтэрнэ гэж Банк үзсэн.





## ХАВСРАЛТ 2 – АМ. ДОЛЛАРООР ИЛЭРХИЙЛСЭН ЗЭЭЛ

### I хэсэг: Хүүгийн талаар Заалт

Хэрэв тухайн Зээлд Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй тохиолдолд Зээлийн Валют нь Ам.Доллар бол 3.04(а) Хэсэгт заасан Холбогдох Зах зээлийн Хүүгийн Хувь нь SOFR Референц Хувь байна.

Банк Хувьсагч Хүүгийн Хувийг мөрдөж буй, Зээлийн Валют нь Ам.Доллараар илэрхийлэгдсэн Зээл, хугацаа хэтэрсэн дүнд тооцох хүүгийн хувь хэмжээний талаар заалтуудад техникийн, захиргааны болон үйл ажиллагааны шинж чанар бүхий бага зэрэг өөрчлөлт оруулах эрхтэй. Ийнхүү оруулсан өөрчлөлт нь Банкнаас Зээлдэгч эсвэл байгаа бол Батлан даагчид нэмэлт өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг өгснөөс хойш Ажлын арав (10) дахь Өдрийн 17:00 цагт (Лондон хотын цагаар), Зээлдэгч эсвэл байгаа бол Батлан даагчаас ямар нэгэн үйлдэл, зөвшөөрөл шаардлагагүйгээр хүчин төгөлдөр болно.

### II Хэсэг: Тодорхойлолт

Хэрэв Зээлийн Валют нь Ам.Доллар бол өөрөөр зааснаас бусад тохиолдолд дараах нэр томъёо нь Стандарт Нөхцөл, Шаардлага болон Стандарт Нөхцөл, Шаардлага үйлчлэх Гэрээнд дор дурдсан утгыг илэрхийлнэ:

“Администратор” гэж Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банк (эсвэл SOFR, SOFR индекс эсвэл Төв Банкны Ханш (Хавсралт В (*Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээ*))-д тодорхойлсон)-ийг удирдаж, нийтлэх ажлыг хүлээн авсан этгээдийг ойлгоно (хамаарах бол).

“Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ” гэж Зээлийн Хүү тооцох Мөчлөг, Хугацаа хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг (эсвэл бусад холбогдох мөчлөг)-ийн хувьд Хавсралт А (*Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ*)-д заасан аргачлалын дагуу Банкнаас тогтоосон жилийн хувь хэмжээг ойлгоно.


“Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь Хэмжээ” гэж Зээлийн Хүү тооцох Мөчлөг, Хугацаа хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг (эсвэл бусад холбогдох мөчлөг)-ийн хувьд Нэмэлт В (*Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээ*)-д заасан аргачлалын дагуу Банкнаас тогтоосон жилийн хувь хэмжээг ойлгоно.

“Индекс Нийтлэгч” гэснийг Зээлийн хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.

“Индексийн Референц Хуудас” гэснийг Зээлийн хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.

“Индекс Нийтлэх Цаг” гэснийг Зээлийн хэлэлцээрт заасан утгаар ойлгоно.

“Хяналтын Мөчлөг” гэж:



(a) доорх (b)-ээс (c) хэсэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд:

(i) хэрэв Индекс Нийтлэгч нь холбогдох индексийг бүх өдөр (SOFR Банкны Өдрүүд биш өдрүүдийг хамааруулан) нийтэлдэг бол 14 өдрийг;

(ii) хэрэв (A) Индекс Нийтлэгч нь холбогдох индексийг зөвхөн SOFR Банкны Өдрүүдэд нийтэлдэг бол, (B) аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг эсвэл бусад холбогдох мөчлөгийн хувьд Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээг Администраторын нийтэлсэн индексээр тодорхойлдог, эсвэл (C) аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг эсвэл бусад холбогдох мөчлөгийн хувьд SOFR Референц Хувь хэмжээг Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээг ашиглан тодорхойлдог бол арван (10) Банкны Өдрийг;

(b) Банкнаас сонгож болох дээр зааснаас урт хугацааг; эсвэл

(c) Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгтэй холбоотойгоос бусад тохиолдолд Зээлдэгчийн зөвшөөрөлтэйгөөр Банкнаас сонгож болох дээр зааснаас богино хугацааг ойлгоно.


**“Хяналтын Мөчлөг Дуусах Өдөр”** гэж (a) холбогдох Хүүг тооцох Мөчлөг буюу Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн сүүлийн өдөр болон (b) Зээлийн аль нэг хэсгийг төлөх ёстой болсон өдрийн аль түрүүнд тохиох өдрийн өмнөх холбогдох Хяналтын Мөчлөг таарч буй өдрийг ойлгоно.

**“Хяналтын Мөчлөг Эхлэх Өдөр”** гэж Хүүг тооцох Мөчлөг эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн эхний өдрийн өмнөх холбогдох Хяналтын Мөчлөг таарч буй өдрийг ойлгоно.

**“Зах зээл Тогтворгүйжих Үйл явдал”** гэж:

(a) аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг эсвэл бусад холбогдох мөчлөгийн хувьд (Зээлийн бүх хэсэг эсвэл аль нэг хэсэг нь Тогтмол Хүүгийн хувь хамаарах мөчлөг эсэхээс үл хамааран) Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ боломжгүй бөгөөд тухайн Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг эсвэл бусад холбогдох мөчлөгийн үед SOFR Банкны Өдөр Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээг тооцох зорилгоор хамаарах SOFR эсвэл Төв Банкны Хувь хэмжээ байгаагүй, эсвэл

(b) аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг эсвэл бусад холбогдох мөчлөгийн хувьд (Зээлийн бүх хэсэг эсвэл аль нэг хэсэг нь Тогтмол Хүүгийн хувь хамаарах мөчлөгийн үед эсэхээс үл хамааран) хүүг тодорхойлох боломжтой болсон өдрийн дараах Ажлын Өдөр Лондон хотод ажлын цаг дуусахаас өмнө тухайн Зээлийг олгохтой холбоотой хөрөнгийн өртөг нь Зах Зээлийн Тогтворгүйжих Хувь хэмжээнээс давсан гэж Банк тогтоосныг ойлгоно.



**“Зах зээл Тогтворгүйжих Хувь хэмжээ”** гэж жилд дараах дүнгүүдийн нийлбэр хувь хэмжээг ойлгоно:

(a)

(i) Холбогдох Зээлийн Хүүг тооцох Мөчлөг эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ; эсвэл

(ii) хэрэв Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ байхгүй бол холбогдох Зээлийн Хүүг тооцох Мөчлөг эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээ; болон

(b) 0.5%.

**“Ажиглалтын Мөчлөг”** гэж Хяналтын Мөчлөг Эхлэх Өдрийг оруулан уг өдрөөс эхлэн Хяналтын Мөчлөг Дуусах Өдрийг оруулахгүйгээр уг өдөр хүртэлх мөчлөгийг ойлгоно.

**“SOFR”** гэж Администратороос удирдаж, нийтэлсэн баталгаат овернайт санхүүжилтийн хүүг (SOFR) ойлгоно.

**“SOFR Банкны Өдөр”** гэж дараах өдрөөс бусад өдрийг ойлгоно:

(a) бямба, ням гараг; болон

(b) Үнэт цаасны Зах зээл, Санхүүгийн Зах зээлийн Холбооноос (эсвэл түүний эрх залгамжлагч байгууллага) АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах зорилгоор гишүүдийнхээ тогтмол орлоготой хэлтсүүдийг бүтэн өдрийн турш хаахыг зөвлөдөг өдөр.

**“SOFR Референц Хувь хэмжээ”** гэж аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөг (эсвэл бусад холбогдох мөчлөг)-тэй холбоотойгоор жилд дараах дүнгүүдийн нийлбэр хувь хэмжээг ойлгоно:


(a)

(i) Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ; эсвэл

(ii) Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ байхгүй бол Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээ; болон

(b) холбогдох Зээлийн Тохируулгын Зөрүү,

хэрэв эдгээр хувь хэмжээний нийлбэр нь тэгээс бага бол хувь хэмжээг тэг гэж үзнэ.



**ХАВСРАЛТ А**  
**НИЙЛМЭЛ SOFR ИНДЕКСИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

Зээлийн аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн хувьд (эсвэл бусад холбогдох мөчлөгийн хуримтлагдсан хүүг тооцох зорилгоор Зээлийг бүхэлд нь эсвэл аль нэг хэсгийг Хүү Төлөх Өдөр эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн сүүлийн өдрөөс өөр өдөр төлөх ёстой болсон тохиолдолд) “**Нийлмэл SOFR Индексийн Хувь хэмжээ**” нь дор дурдсаны дагуу тооцсон жилийн хувь хэмжээ (аравтын дөрвөн орон хүртэл тоймлосон)-г ойлгоно:

$$(\text{SOFR Индекс}_{\text{дуусах}} / \text{SOFR Индекс}_{\text{эхлэх}} - 1) \times (360/n)$$

үүнд:

“**n**” гэж Ажиглалтын Мөчлөгт хамаарах өдрийн тоог ойлгоно;

“**SOFR Индекс**<sub>дуусах</sub>” гэж дараах этгээдүүдийн нийтэлсэн индексийн утгыг ойлгоно:


(a) Индекс Нийтлэгч Хяналтын Мөчлөг Дуусах Өдөр Индекс Нийтлэх Цагт эсвэл үүнтэй ойролцоо хугацаанд Индексийн Референц Хуудсан дээр нийтэлсэн; эсвэл

(b) хэрэв Индекс Нийтлэгч нь Администратораас өөр бөгөөд энэхүү тодорхойлолтын (a) догол мөрөнд эсвэл SOFR Индекс<sub>эхлэх</sub>-ийн тодорхойлолтын (a) догол мөрөнд заасны дагуу холбогдох мөчлөгийн хувьд SOFR Индекс<sub>эхлэх</sub> эсвэл SOFR Индекс<sub>дуусах</sub>-г тодорхойлох боломжгүй бол (байхгүй байгааг хамааруулан) Хяналтын Мөчлөг Дуусах Өдөр 15:00 цагт (Нью-Йоркийн цагаар) эсвэл ойролцоо цагт Администратор <https://apps.newyorkfed.org/markets/autorates/sofr-avg-ind>-д нийтэлсэн;

“**SOFR Индекс**<sub>дуусах</sub>” гэж дараах этгээдүүдийн нийтэлсэн индексийн утгыг ойлгоно:

(a) Индекс Нийтлэгч Хяналтын Мөчлөг Эхлэх Өдөр Индекс Цагт эсвэл үүнтэй ойролцоо хугацаанд Индексийн Референц Хуудсан дээр нийтэлсэн; эсвэл

(b) хэрэв Индекс Нийтлэгч нь Администратораас өөр бөгөөд энэхүү тодорхойлолтын (a) догол мөрөнд эсвэл SOFR Индекс<sub>дуусах</sub>-ийн тодорхойлолтын (a) догол мөрөнд заасны дагуу холбогдох мөчлөгийн хувьд SOFR Индекс<sub>эхлэх</sub> эсвэл SOFR Индекс<sub>дуусах</sub>-г тодорхойлох боломжгүй бол (байхгүй байгааг хамааруулан) Администратор Хяналтын Мөчлөг Эхлэх Өдөр 15:00 цагт (Нью-Йоркийн цагаар) эсвэл ойролцоо цагт <https://apps.newyorkfed.org/markets/autorates/sofr-avg-ind>-д нийтэлсэн.



## ХУРИМТЛАГДСАН НИЙЛМЭЛ SOFR ХУВЬ ХЭМЖЭЭ

Зээлийн аливаа Хүүг тооцох Мөчлөг, Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн хувьд (эсвэл бусад холбогдох мөчлөгийн хуримтлагдсан хүүг тооцох зорилгоор Зээлийг бүхэлд нь эсвэл аль нэг хэсгийг Хүү Төлөх Өдөр эсвэл Хугацаа Хэтрүүлсний Хүүг тооцох Мөчлөгийн сүүлийн өдрөөс өөр өдөр төлөх ёстой болсон тохиолдолд) **“Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээ”** нь дор дурдсаны дагуу тооцсон жилийн хувь хэмжээ (аравтын дөрвөн орон хүртэл тоймлосон)-г ойлгоно:

$$\left[ \prod_{i=1}^{d_0} \left( 1 + \frac{\text{DailyRate}_i \times n_i}{d_{cc}} \right) - 1 \right] \times \frac{d_{cc}}{d}$$

ҮҮНД:

“d0” - Ажиглалтын Мөчлөгт хамаарах SOFR Банкны Өдрийн тоо;

“i” - тус бүр нь Ажиглалтын Мөчлөг дэх холбогдох SOFR Банкны Өдрийг он цагийн дарааллаар илэрхийлэх нэгээс  $d_0$  хүртэлх бүхэл тоонууд;

“**n<sub>i</sub>**” – аливаа SOFR Банкны Өдөр “**i**” хувьд тухайн SOFR Банкны Өдөр “**i**”-г оруулан энэ өдрөөс эхлэн дараагийн SOFR Банкны Өдрийг оруулахгүйгээр энэ өдөр хүртэл өдрийн тоог ойлгоно.

**“dcc”** - 360;


“d” - тухайн Ажиглалтын Мөчлөгийн өдрийн тоо;

“DailyRate” - Ажиглалтын Мөчлөгийн хугацаан дахь аливаа SOFR Банкны Өдөр “i”-ийн хувьд тухайн SOFR Банкны Өдөр “i”-ийн Өдрийн Ханш.

“DailyRate”-л дараах тодорхойлолтыг хэрэглэнэ:

**“Төв Банкны Ханш” гэж:**

- (a) Администратораас тухай бүр нийтэлсэн АНУ-ын Холбооны Нээлттэй Зах зээлийн Хорооноос тогтоосон богино хугацааны хүүгийн зорилтот хувь эсвэл түүнийг орлуулах хувь хэмжээг; эсвэл
- (b) хэрэв зорилтот хувь нь ганц тоо биш бол дараах тоонуудын арифметик дундаж:





- (i) АНУ-ын Холбооны Нээлттэй Зах зээлийн Хорооноос тогтоож, Администратор нийтэлсэн богино хугацааны хүүгийн зорилтот хязгаарын дээд зааг; болон
- (ii) зорилтот хязгаарын доод зааг.

“Төв Банкны Ханшийн Тохируулга” гэж SOFR боломжтой шууд өмнөх арван SOFR Банкны Өдөр тухайн SOFR Банкны Өдрийн SOFR болон тухайн SOFR Банкны Өдрийн Төв Банкны Ханшийн арифметик дунджийг ойлгоно.

“Өдрийн Ханш” гэж аливаа SOFR Банкны Өдрийн хувьд:

- (a) тухайн SOFR Банкны Өдрийн SOFR; эсвэл
- (b) тухайн SOFR Банкны Өдөр SOFR боломжгүй бол жилд дараах дүнгүүдийн нийлбэртэй тэнцэх хувь:
  - (i) тухайн SOFR Банкны Өдрийн Төв Банкны Ханш; болон
  - (ii) холбогдох Төв Банкны Ханшийн Тохируулга; эсвэл
- (c) хэрэв дээрх (b) догол мөр хамаарах боловч тухайн SOFR Банкны Өдрийн Төв Банкны Ханш боломжгүй бол жилд дараах дүнгүүдийн нийлбэртэй тэнцэх хувь:
  - (i) тухайн SOFR Банкны Өдрөөс хоёроос илүүгүй SOFR Банкны Өдрийн өмнөх хамгийн сүүлийн Төв Банкны Ханш; болон
  - (ii) холбогдох Төв банкны Хүү

аль аль тохиолдолд дөрвөн аравтын бутархай болгон тоймлоно.

Хуримтлагдсан Нийлмэл SOFR Хувь хэмжээг тооцоход Хүүг тооцох Мөчлөг эсвэл Хугацаа Хэтэрсний Хүүг тооцох Мөчлөгийн аль нэг өдөр нь SOFR Банкны Өдөр биш бол тухайн өдрийн Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь өмнөх SOFR Банкны Өдөр хамаарах хувь хэмжээ байна.

